Л.ТЭРБИШ

МОНГОЛ ЗУРХАЙ СУДЛАЛ
ҮРИЙН ЗУРХАЙ БОЛОР ТОЛЬ

འབྲས་རྩིས་ཤེལ་གྱི་མེ་ལོང་།

(Гутгаар дэвтэр)

Улаанбаатар хот.
2011 он

ОРШИЛ

Монголчуудын төвд хэлээр зохиосон утга зохиолын дотор зурхайн ухааны аймаг савын ном томоохон байр суурийг эзлэнэ. Тухайлбал, бидний судалгаагаар төвд хэлээр зурхайн зохиол туурвисан монгол хүмүүс гэхэд л ная гарад байна. Тэдний бичсэн зохиол туурвил нь гурван зуу хол давсан буй. Зурхайн ухааны эл бүтээл туурвилууд нь одон хийгээд хар зурхайн аймаг савд хамаарагдаж буй.

Одон зурхай хэмээх нь наран, саран, таван гараг хийгээд утаат сүүлт од, нар сарны хиртэлтийн хөдөлгөөн байршилыг олох аргыг үзүүлсэн од зүй, тооны ухаан хавсармал **өвөрмөц онол болно**. **Хар зурхай** нь махбодын зурхай буюу гараг, эрхэсийн орчил хөдөлгөөнөөс хамаарах элдэв **хэм хэмнэлийг тогтоох ухаан** бөгөөд дотроо **амьдын, бэрийн, үхэгсэдийн** хэмээн гурав ангилагддаг. Эдүгээ бидэнд мэдэгдэж байгаагаар монголчуудаас төвд хэлээр хамгийн анхны томоохон зурхайн бүтээл туурвисан хүмүүн бол Ламын гэгээний анхдугаар дүр Лувсанданзанжанцан (1639-1704) юм. Тэр бээр 1689 онд тангад, монгол шавь нарынхаа эгээрлийг хангаж "Үрийн зурхайн сайн номлол бүхний хураангуй" хэмээх алдартай бүтээлээ туурвиж, зурхайн ухааныг монгол газар шороонд идээшүүлсэн билээ. Эл зохиолыг миний бие 1991 онд орчуулж олны хүртээл болгосон юм. Одоо уншигч танаа толилуулан буй "Таван хураангуй махбодын барилдлага тэргүүтний үрийн номлол онц гайхамшигтай болор

толь оршвой" номын талаар хэдэн үг дурдая.

Эл зохиол нь нэлээд хожуу зохиогдсон боловч буриад, барга, ар, өвөр монгол хийгээд тангад, монгол, хотон зэрэг олон үндэстэн ястны нутаг болсон Амдуу газрын Лавран хийдэд хүртэл түгэн дэлгэрч, зурхайч нарын гол гарын авлага болсон байна. Тухайн бүтээл чингэж өргөн дэлгэр тархсан нь цаг үеэ олж гарсантай холбоотой юм. Онолтой шүнтэй зурхайн ухаан учир мэдэхгүй хүмүүсийн олз завшаан болсон цөвүүн цагийн эхэнд буриадын Агын Дэчэнлхүндэв хийдийн гавж, зурхайч Лувсанбалжор эл зохиолыг туурвижээ. Тэрээр номынхоо төгсгөлийн шүлэгт "Энэ цөвүүн цагийн "Алаг цаас"-нд шүтэн хуурагчид хөөрхийс өрөвдлийн орон" хэмээн зурхайн ухааныг ашиг завшаан болгогчдыг шүүмжлэн шантайлгасан байна. "Алаг цаас" гэж тухайн хүмүүний хэрэгцээг хангасан, хүснэгт голлосон түүвэр жижиг номыг хэлдэг. Түүнийг төвдөөр шогт гэдэг юм. Манай эрдэмтэн өтгөс "Даяг хараад гүүш болдоггүй. Шогт хараад зурхайч болдоггүй" хэмээн айлддаг байсан нь дан үгээр хөөцөлдөөд утгыг онохгүй, ганц нэг түүвэр хүснэгт хараад зурхайн ухааны мөн чанарыг мэдэхгүй" хэмээн ихэд анхааруулан сургасан үг билээ. Ер нь манай ард түмэн "Хүрээн дээр суусан чавганцын чих шарлана" гэж ярьдаг нь чиса, сүлд гараг гэх мэт жижиг зүйлсийг хүмүүн бүр мэддэг, чингээд ямар ч "Зурхайч" үгүйгээр түүнийг амьдрал ахуйдаа хэргэлэж заншсаныг хэлсэн хэрэг. Лувсанбалжор "Алаг цаас"-нд шүтэн өөрийгөө зурхай ч хэмээн ардыг хуурагчдыг шүүмжилж, зурхайн ухааны хамгийн гол ойлголт болох таван хураангуй, махбодын учрал тохиол хийгээд тэдний шим мандалд үзүүлэх эерэг, сөрөг нөлөөлөл буюу үрийг

тухайн зохиолдоо тодорхой тайлбарлан бичсэн байна. Бас бидний гарт баригдаж, нүдэнд үзэгдэхгүй атлаа бидэнд бодатай нөлөө хүчийг үзүүлэн байдаг, эрхэсийн таталцал, түлхэлцэлтэй холбоотой газрын эздийн гүйлт, буулт, буцалт зэргийн талаар тун тодорхой өгүүлсэн нь хэрэглээний болон судалгаа шинжилгээний ихээхэн ач холбогдолтой болох нь мэдээж. Лувсанбалжор зурхайч тухайн зохиолынхоо хэрэглээний ач холбогдлыг дурдан төгсгөлийг үгэндээ:

“Одон хийгээд хар зурхайн аймаг савын
ариун гүнзгий болор орноос
Онц гайхамшигт явдлын сайтар номлолын
дүрс үзэгдэл лагчааг барьсан
Он жилийн лит тооллыг тайлан үйлдэгч
сонихон энэ толиноо
Огт харахгүй алмайрагч шудрага агч
шинжлэл төгөлдөртөн хэн байх билээ”

хэмээн бичжээ. Өөрөөр хэлбэл гараг, эрхэсийн нэгэн жилийн хөдөлгөөн байршилыг тооцоолон бодоод, түүнийгээ жилийн товчоон болгон гаргадаг лит буюу цаглабарын тайлбар болгож тухайн бүтээлээ туурвиснаа дурдсан байна. Төгсгөлийн үгээс харвал Лувсанбалжор эл зохиолоо эмч гэлэн Цүлтэмийн дурдсанаар аргын тооллын 1908 онд харгалзах “Арван тавдугаар сайтар гарсаны шороон эр бичин жилийн Шошаг” буюу зуны тэргүүн сарын шинийн долооны өдөр бичиж төгсгөсөн байна. Мөн төгсгөлийн үгэнд:

“Учир шалтгааныг дээр тодотгосон ариун
гэлэн Цүлтэм
Учирыг эвсүүлэн их хүрээ дагшин орон
Дэчэнлхүндэв тивд

Уламжилж хэвийг бүтээсний буянаар
хойт Шамбалын орноо
Угсаа залгамжлан суугч Ригдэнгийн
зарлигийг сонсох
газраа түргэнээ одтугай"

хэмээснээс харвал дуртгаач тухайн номын хэвийг сийлж олны хүртээл болгожээ. Хожим нь аргын 1915 онд харгалзах Арван тавдугаар жарны модон туулай жилийн зуны тэргүүн сарын шинийн дөрвөнд Дармамонга хэмээх хүмүүн мөн хийдэд "Онц гайхамшигтай болор толийн өнцгийн чимэг жил, сар, өдөр, цагийн газрын эзэд тэргүүтний зурхайн үр тод зул" хэмээх номыг зохиожээ. Эл зохиол нь өгүүлэн буй номын бэрийн зурхай, үхэгсэдийн зурхай хоёрыг дэлгэрүүлэн тайлсан бүтээл болжээ. Мөн хийдэд бартай. Өмнөх хоёр зохиолыг хожим нь Нийслэл хүрээнд модон хэвээр дахин хэвлэсэн бөгөөд хэв нь нэлээд алдаа, мадагтайг дурдууштай. "Болор толь" нь монгол орны өргөн уудам газрын хуваарьт тохирсон "Төгс буянт шинэ зурхай"-н ёсонд тохируулан хийсэн үрийн зурхайн зохиол тул эдүгээ ч ач холбогдолтой хэвээр байна. "Болор толь"-ийг миний зарлигийн ачит багш мэргэн зурхайч нар болон, номтой шүнтэй лам нар өдөр тутмын гарын авлага болгон хэрэглэж байсан тул "Орчуулж, түмний хүртээл болгохсоно" хэмээн бодлож явсан билээ. Бас одоогоос арван нэгэн жилийн өмнө МУИС-ийн ахмад багш, тэр үед ерэн сүүдрийг гаталсан нэрт манжич Я.Шаарийбүү гуай энэ зохиолын нэгэн хувийг миний биед бэлэглэж, "Монголоор орчуулбал сайн сана" хэмэхүйд, "Энэ номыг тань орчуулж, олны хүртээл болгоё" хэмээн ам алдсанаа давхар санагалзаж, чадан ядан орчуулаад,

Отвязаться от неприятностей.
3) Когда увидите п. проц-ю, возьмите п-у собой пальцами в правую руку и вытрите её вслед, говоря:

зурхайн нэр томъёонд зохих тайлбар хийж уншигч олноо тольлуулж тэр дорхноо дууссан билээ. Эдүгээ заримууд дахин хэвлүүлээч хэмээн хүссэн тул цөөн тоотой хэвлүүлснээ давхар өчсү!

Гэм алдал болсныг гэгээн мэргэд болгоон таалах ажаамуй.

„Тебя мертвец несут,
и пусть к тебе
все мои горести возьмут"

50
10/50

Монголын Үндэсний ШУА-ийн академич,
шинжлэх ухааны доктор, профессор
Урианхай овогт Лхасрангийн ТЭРБИШ

Или встаньте у ц-ви так, чтобы вас покрывала ц. тень, и говорите:

„Укрой меня, тень церковная,
Своим святым покрывалом,
Как когда-то Богородица Христа укрывала,
от всякой беды, от всякой масти,
От козней людей, от нападения зверей,
От страха, от вреды, от [illegible] вреды,
От нож[illegible] в ночи, от огня из печи,
От предательства, от суда, от всякого тайного вреда.
От порчи и от голодной сумы,
От разорения и от нищеты,
От всех бед, какие бывают, и от бед, которых желают.
Будь, тень церковная, всегда со мной,
Богородицыным Покровом укрой.
Во имя Отца и Сына и Святого Духа.
Ныне, присно, во веки веков.
Аминь."

ТАХИЛЫН ШҮЛЭГ

Цогт Цагийн Хүрдэнд мөргөмүй.
Туурвил бүхний чухал амирлагч (гал) бүхнээ
түгсэн бэлгэ билгийн мөн чанарт
Түгдам сэтгэл зуунтааг төгсгөн илби хувилгааны
лагшинд боссон
Тууурвилт тоолшгүй амьтныг нэгэн агшнаа
хөтлөхдөө их баатар хүчин төгөлдөр
Туулсан бурхан Ялж Төгс Нөгчсөн [1] Цагийн
Хүрдэн [2]-д зүрхний угаас сөгдмүй.
Орчихуй зам үүнээ зарлигийн ач нь ханьцаш үгүй
Сайн Саран [3] хаанаас
Одоо хүртэл дамжин ирсэн бодатай үндэслэлийн
лам нарын чуулганд мөргөөд
Олноо хэрэгтэй таван хураангуй [4] тэргүүтний
чухал хэрэгтэй лагшаа тоотойг дэлгэн
Онц гайхамшигтай энэхүү болор толь хэмээхүйд
байгуулан сүндэрлүүлсү би!

Тэр ч, гараг, өдөр, одон, барилдлага, үйлдэгч тав тус, тусын сайн, муугийн ялгамж хийгээд махбодын учрал тэргүүтэн хийгээд даруйд хэрэгтэй зарим нэгэн сэлт долоог үзүүлнэ.

ГАРАГИЙН ҮР

Ээлжийн гараг нь лит [5]-ний зурагт ургасан [6] гараг бөгөөд үүр цайхаас үүр цайхын хооронд бүтэн нэгэн нарны хоногийг эрхшээх бөлгөө. Үүнд:

Адъяа нь гал махбода [7]-тай их хүмүүний сүлд [8] гараг болой. Энэ гараг эрхшээсэн өдөр [10]-т шүтээн амлуулах (Үүнээс хойш шүтээнийг амлуулах гэдгийг, амлуулах гээд явна, Орч), абшиг эш тэргүүтнийг хайрлах, түшмэлд тушаах, хурим найр хийх, тариа төмс тэргүүтний хөрөнгө талбих, морь мал сургах, эм найруулах, тойн болох тэргүүтэн өлзийг үйлдэхүй буяны үйлд сайн. Байшингийн суурь талбих, хувцас эсгэх, эд агуурсыг гадагш өгөх, ханyyр, төөнүүр хийхийг тэвч. Бэр авбаас дахин, дахин буцах тул бүү ав. Үхэгсэдийн үйлээс хүүрийг түлэхээс бусад нь муу. Хүүр түлэх сайн. Хүмүүн үхвээс амьдад муу. Өвчин болвоос цагаан, улаан идээг дагаж ирсэн зэтгэрийн хорлол болжээ. Алдуул, завхуул болохын цагт эрдэнийн зүйл болвоос үл олдоно. Морь, мал тэргүүтэн амьтан болвоос өмнө зүгт эрвэл олдоно. Сэжиг гарахүй муу ёр болвоос үзсэн хүмүүнд муу. Хур орвоос дунд зэрэг. Хөвгүүн төрвөөс нас нь урт, их асралт хүмүүн болно. Охин төрвөөс баялаг болмуй.

Сумъяа нь усан махбодатай, бүсгүй хүмүүний сүлд гараг. Хишиг даллага дуудуулах, эм найруулах, тэнгэр лусыг тахих, хөрөнгө талбих, сүм хийд хийгээд шүтээн босгох, бэрийн үйлд сайн. Ном сонсох, замд гарах, шинэ хувцас өмсөх, эд эдэлбэр гадагш өгөх, хүүр

түлэхд муу. Үхвээс бусдад гэм үгүй. Өвчин болвоос бэлбэсэн эмийг дагаж ирсэн үхэгсэдийн зэтгэр [10], лус, мангасын хорлол болсон. Алдуул, завхуул болвоос хойт зүгт цагаан царайтай, шар үстэй, хар нохойтой хүмүүн аваачсан. Муу ёр болвоос усны аюул болох хийгээд түшмэлд муу. Хур бууваас олонтоо арвижна. Хөвгүүн төрвөөс баялаг ба хатуу ширүүн хүмүүн болно. Охин төрвөөс сэтгэлд зохистой, тус хэргийг бүтээгч болмуй.

Ангараг нь гал махбодатай, асур [11]-ын сүлд болно. Дайсан, тотгорыг номхотгох, худалдаа хийгээд цэргийн үйл, хатуу үйлд сайн. Эм найруулах, замд гарах, бэрийн үйлийг тэвч. Хүүр хийгээд үхэгсэдийн үйлийг ч тэвч. Үхвээс эдэд муу. Өвчин болвоос халуун хижигийн эзний хорлол болсон. Алдуул, завхуул болвоос өмнө зүгээс олдоно. Өмнө шадар хийгээд хожимоо тохирохгүй болсон хүмүүн буй бол шинж. Муу ёр болвоос хилэнцэт явдалд муу. Хур бууваас ган болно. Хөвгүүн төрвөл амьдрах нь бэрх ба хилэнцт явдалтан, омог дээрэнгүй ихтэн, охин төрвөөс нас нь охор болно.

Буд усан махбодатай, ягчис [12]-ын сүлд гараг. Эдийг бүтээх, хишиг даллага дуудуулах, үсэг зурхайд суралцах, шадар хамаатан бололцох, худалдаа арилжаа тэргүүтэн өөрийн хэрэгтэй үйлд сайн. Хатуу үйлийг тэвч. Бэр авбаас охин төрнө. Эр хүмүүн үхвээс боол, зарцдаа муу. Эм хүмүүн үхвээс гэм үгүй. Өвдвөөс банди бомбын хараал, лусын хорлол болжээ. Алдуул, завхуул болвоос хойт зүгээс эрэх хэрэгтэй. Нялхас буюу бүсгүй хүмүүнээс хэл дуулна. Ёр болвоос ус, мөрний хорлол болно. Хур бууваас хойшдоо хур зүсэрмүй. Хөвгүүн төрвөөс өвдөх нь олон, эхдээ ширүүн. Охин төрвөөс эд,

малд муу болой.

Бархасвадь нь хий махбодатай бандийн сүлд гараг. Үсгийн эрдэм ухаан, ид хүчинд суралцах, номлох, сонсох тэргүүтэн номын үйл, замд гарах, эм найруулах, хөрөнгө тавих хийгээд буяны үйл зонхид сайн. Бэр авбаас хөвгүүн төрнө, цог төгөлдөр болно. Үхвээс өчүүхэн төдий муу. Өвдвөөс шөнийн жуулчны зэтгэр хийгээд газрын эзэн, хан адын хорлол болно. Алдуул, завхуул болвол дорно өмнө зүгт бэдэрвээс олдоно. Муу ёр болвоос тойн хийгээд ведийг үйлдэгчид муу. Хур бол дунд. Хөвгүүн төрвөөс оюун ухаан сайтай, мэргэн, номыг үйлдэгч болно. Охин төрвөөс нас нь урт хийгээд нөхөртөө ч сайн болой.

Сугар нь шороон махбодатай, ноён хүмүүний сүлд гараг. Номыг тэтгэгчийг тахих, тойн болох, эм найруулах, хурим найр хийх, замд гарах, ухаанд суралцах, бэр хийгээд үхэгсэдийн үйлд сайн. Өр төлөх, нүүдэл суудал хийх зэрэгт муу. Үхвээс гэм үгүй. Өвдвөл хан ад хийгээд албины хорлол болсон. Алдуул, завхуул болвоос өмнө өрнөөс сураг дуулна. Ёр болвоос бүсгүй хүмүүнд муу. Хур бууваас сайн. Хөвгүүн төрвөөс насан урт болно. Эрх хүч ихтэй, баялаг болно. Охин болвоос цог хийморь их ч өвдөх нь өчүүхэн болно.

Санчир нь шороон махбодатай, нялхасын сүлд гараг. Нас, эдийг бүтээх, эд малыг авах, худаг малтах, тариалан хийгээд барилгын үйлд сайн. Бусад үйл зонхийг тэвч. Үхвэл эдэд муу. Өвдвөөс эрлэгийн хорлол болсон тул гэм ихтэй. Алдвал өмнө өрнө зүгт авч одсон буюу хуучин хувцастай банди хүмүүнийг шинжил. Ёр болвол муу. Хур дунд зэрэг. Хөвгүүн төрвөл дунд зэрэг. Охин төрвөөс нас нь охор болой.

От напущенной бессонницы

Тусгайлан ялгах нь : Адъяа парагт огторгуйн үүд дэлгэрдэг ч үхэгсэдийн буяныг (ཞེད།) үл үйлд. Сумъяа гарагт лусын үүд дэлгэрдэг ч хом [13] бүү шатаа. Ангараг гарагт хутганы га раг дэлгэрдэг ч хутгыг бүү ирлэ. Буд гарагт үр тасрахын үүд дэлгэрдэг ч үхээрийг бүү талби. Бархасвадь гарагт модон гараг дэлгэрдэг ч сор бүү орхи. Сугар гарагт малын гараг дэлгэрдэг ч малыг бүү хөдөлгө. Санчир гарагт шороон гараг дэлгэрдэг ч эдийг бүү гарга. Ер нь бодагал алины сүлд гараг ургаваас хэрэг нь бүтэх сайн болой. Бас бус цэрэг хийгээд замд гарах, тус хэрэг тэргүүтнээ дорноос дорно өмнө тэргүүтэнд Адъяа, Сугар, Ангараг, Раху, Санчир, Сумъяа, Буд, Бархасвадь гарагуудыг байрлуулж, Адъяа ургахын үед дорноо одвоос буянтай, усны эзэнд муу мөний тул түүгээр жишиж, үлдсэнийг мэдэх бөлгөө. Өөрийн зүг сайн ба зүг, завсар бусдад муу болохоор сайн шинжилж, авч, огоорохыг үйлдээрэй.

Дождитесь новолуния и, глядя на молодой месяц, скажите так:
«Князь молодой, рог золотой,
Тебе, доброму молодцу, по ночам гулять
А мне, рабу Божьему (имя),
По ночам крепко спать.
Во имя Отца и Сына и Святого Духа.
Ныне и присно и во веки веков.
Аминь.»

ӨДРИЙН ҮР

Шинийн хоног нь сарны арвидал, хомсдлын хувьд шүтэж гарах болно. Түүний эхийг хатгах завсар ба эхлэх, төгсөх завсарыг гарагийн эдэлбэр [14]-д шүтэж, ухаарах хэрэгтэй болно. Түүнд, **"Гараг хийгээд өдрийн эдэлбэр ирээдүй"** хэмээн зарлигласан болохоор зурагт ургасан нь одоо эдлэх эдэлбэр ургасан нь болой. Тэр ч үлгэрлэвээс, арван мөч тэргүүтэн одоо ургахын үест тэр өдрийн үүр цайхаас эхлээд тэр өдрийг дуустал тэр өдрийг эрхшээн үйлдэх болно. Түүний тулд нарны хоногийн нэгэн өдрийн өдөр дундыг хүртэл шинийн нэгэн хийгээд, үд хэвийхээс нааш шинийн хоёронд орох мэт болой. Тэдгээрийг тус, тусад нь авч, огоорохыг гарагийн эдэлбэр лүгээ тохируулж үйлдэх хэрэгтэй юм. Нарны хоног лугаа тохируулж үл үйлдэх болно.

Тэр ч хоёроос **Анхдугаарт**, Өдөр тус, тусын өгүүлэл нь:

Шинийн нэгэнд санасан үйлийг бүтээх, худаг малтах, тариалангийн газрыг хагалах мэт анх газрын ам нээх, буян тогтоохын эх хатгах, бусдын газар очих замд гарах тэргүүтэн амирлангүй үйлд сайн. Ном сонсох, үхэгсэдийн үйл, бурхныг тахих, зэтгэрийг дарахыг тэвч. Өвдвөл хиншүү хярвас тавьсан хийгээд эртийн хувийн (Эрт ирсэн, Орч) жуулчны гэмийн үзэгдэл болжээ.

Шинийн хоёронд лам болох, түшмэлд тушаах, амьлуулах, гал голомтыг үүсгэх, хөрөнгө тавих тэргүүтэн дэлгэрүүлэх үйлд сайн. Замд гарах, өглөгийн түллэгийг тэвч. Өвдвөл ариун бусын буртаг хийгээд

бурхан хилгэнэсэн амой.

Шинийн гурванд замд гарах, гэр бүрэх, гал голомтыг үүсгэх тэргүүтэн дэлгэрэнгүй үйл хийгээд эрхшээх үйлд сайн. Боолыг шүтүүлэх, худаг малтахыг тэвч. Өвдвөл тэнгэр, ад, хан адын хорлол болжээ.

Шинийн дөрвөнд бэр, худалдаа, арилжаа, тариалангийн үйл хийгээд цагаан зүгийн үйлд өлзийтэй. Хэрүүл, тэмцлийг тэвч.

Шинийн тавaнд ном унших, замд гарах, ирэх тэргүүтэн амирлангуй үйлд сайн. Тариалан, үхэгсэдийн үйлийг тэвч.

Шинийн зургаанд нас, эдийн бүтээл, худалдаа ба тариалан тэргүүтэн дэлгэрүүлэх үйл зонхид сайн. Гадагш өгөх тэргүүтнийг тэвч.

Шинийн долоонд ус хийгээд үхэгсэдийн үйлд сайн. Боол шүтүүлэх, бэрийн үйлийг тэвч.

Шинийн наймaнд гурван шүтээн [15]-ийг босгох, амьлуулах хийгээд ихэдгэх [16], дайсныг номхотгох, зэтгэрийг дарах зэрэгт сайн. Замд гарах, тариалан, бэрийн үйл, хувцас эсгэхийг тэвч.

Шинийн есөнд замд гарах, худалдаа арилжаа тэргүүтэн амирлангуй хийгээд хатуу үйлд сайн. Боолыг шүтүүлэх, бэр ба үхэгсэдийн үйлийг тэвч.

Шинийн арванд дуган сүм, шүтээнийг босгох, тахих тэргүүтэн ихэд арвижуулах үйлнээ сайн. Замд гарвал муу тул тэвч.

Шинийн арван нэгэнд баяр хурим тэргүүтэн амирлангуй, дэлгэрэнгүй үйлд сайн. Хатуу үйлийг тэвч.

Шинийн арван хоёронд шүтээнийг босгох, гал голомт үүсгэх, хөрөнгө тавих тэргүүтэн амирлангуй

үйлд сайн. Замд гарах, боолыг шүтүүлэх, мал худалдан авахыг тэвч.

Шинийн арван гурванд барилга тэргүүтэн шороо, газрын үйл, замд гарах, ихэтгэх, дэлгэрэнгүй үйлд сайн. Боолыг шүтүүлэх, мал худалдан авахыг тэвч.

Шинийн арван дөрвөнд тойн болох, мал худалдан авах, балгадын үйл, замд гарах эрхшээх үйлд сайн. Номлох, сонсох, үр тавих, боолыг шүтүүлэхийг тэвч.

Шинийн арван таванд гэр барих, шүтээн босгох, амьлуулах, үр талбих, хишиг даллага дуудуулах, хатуу үйлд сайн. Тангараглах, нүүдэл суудал хийх, үхэгсэдийн үйл, бэрийн үйлийг тэвч.

Арван зургааны өдөр боолыг шүтүүлэх, эд худалдан авах, газрын амыг нээх, амирлангуй үйлд сайн. Замд гарах, амьлуулах, хэрүүл тэмцлийг тэвч.

Арван долоонд замд гарах, худалдан авах, арилжаа хийх, балгадын үйл, үхэгсэдийн үйл ба дэлгэрүүлэх үйлнээ сайн. Бэрийн үйл, өглөгийн түллэгийг тэвч.

Арван найманд буяны үйл ба хөрөнгө тавих, бугийг дарахад сайн. Замд гарах, үхэгсэдийн үйлийг тэвч.

Арван есөнд замд гарах, бугийг дарах, амирлангуй үйлд сайн. Бэр, үхэгсэдийн үйл, мал худалдан авахыг тэвч.

Хоринд дэлгэрүүлэх үйл бүхнээ сайн. Замд гарахыг тэвч.

Хорин нэгэнд замд гарах, хөрөнгө талбих, эрхшээх үйлд сайн. Боолыг шүтүүлэх, бэрийн үйл ба ихэтгэхийг тэвч.

Хорин хоёронд үсэг, зурхай, урлахуй ухаанд суралцах, хөрөнгө талбих, бугийг дарах, хатуу үйлд

сайн. Замд гарах, бэрийн үйл хийгээл үхээрийн үйлийг тэвч.

Хорин гурванд амьлуулах, мөрд гарах, балгадын үйл хийгээд өглөгийн түллэг зэрэгт сайн. Худаг малтах, боолыг шүтүүлэх, мал худалдан авахыг тэвч.

Хорин дөрвөнд замд гарах, боолыг шүтүүлэх, дэлгэрүүлэх үйлд сайн. Амьлуулахыг тэвч.

Хорин тавaнд замд гарах, хөрөнгө тавих, үхэгсэдийн үйл, худалдаа, арилжаанд сайн. Боолыг шүтүүлэх, ихэтгэхийг тэвч.

Хорин зургаанд газар малтах, хөрөнгө талбиваас сайн. Замд гарах ба мал худалдахыг тэвч.

Хорин долоонд замд гарах ба үхэгсэдийн үйл, хөрөнгө тавих тэргүүтэн дэлгэрүүлэх үйлд сайн. Боолыг шүтүүлэх, бэрийн үйлийг тэвч.

Хорин наймaнд өглөгийн түллэг, эрхшээх үйлд сайн. Үхэгсэд ба бэрийн үйлийг тэвч.

Хорин есөнд дайсныг номхотгох, бугийг дарах тэргүүтэн хатуу үйлд сайн. Боолыг шүтүүлэх, бэр хийгээд үхэгсэдийн үйл, мал худалдан авахыг тэвч.

Гучинд хөрөнгө тавих, эрхшээх ба хатуу үйлд сайн. Үхэгсэдийн үйл, бэрийн үйлийг тэвч.

Хоёрдугаарт, Үйл лүгээ зохилдуулсан өгүүлэл нь:

Шинийн нэгнээс эхлээд дараалан баясгалан, сайн, ялгуусан, хоосон, төгс хэмээх бөлгөө. Энэ тавуул гучин хоногт зургаан удаа орчих тул шинийн нэгэн, арван нэгэн, хорин нэгэн буюу гурван нэгэн, шинийн зургаан, арван зургаан, хорин зургаан буюу гурван зургаан нь баясгалан, түүнчлэн шинийн хоёрон тэргүүтэн гурван хоёр, шинийн долоон тэргүүтэн гурван долоон нь сайн мөн. Гурван гурван ба гурван найман нь ялгуусан,

гурван дөрвөн ба гурван есөн нь хоосон, гурван таван ба гурван арван нь төгс мөн болой. Тэдгээрээс,

Баясгалан нь урлахуй ба наадгай хийх, цагаан зүгийн буяны үйл, амирлангуй үйлд сайн.

Сайн нь нөхрийг эрэн олохуй, хөрөнгө талбихад сайн.

Ялгуусан нь дайсныг номхотгох, хэрүүл, тэмцэл хийх, хариулга балин гаргах тэргүүтэн хатуу үйлд сайн.

Хоосон нь үйл алинд ч муу.

Төгс нь ер нийтэд муу ч балгад босгох, хумх санд нуухуйд сайн. Тэднээс хоосон өдөрт их үйлийг туурвих, нас хийгээд эдийг үргэлжлүүлэхүй тогтоол урих, төгс өдөрт өлзий хутаг давхарласан хийгээд өлзий хутгийн хэргийг бүтээгч номуудыг уншин дуурьсгахуйд сайн болой. Өмнө номлосон тэдгээрээс аль өдөрт аль үйл сайн хийгээд муугийн номлол нь ач, хорлол ихтэй тул бодтой өгүүлсэн болой. Алиныг ч өгүүлэл үгүй адил тэгшид тавибаас ач, хорлол үгүй мөн болой. Гараг, одны үрд ч энэ аньстайг мэдэх хэрэгтэй болой.

Поясница: Растопите стакан мёда с половиной стакана соли и ста граммами топлёного сала. В получившуюся массу добавьте [illegible] размером с грецкий орех. Намажьте поясницу, накройте её сверху целлофаном и закутайтесь получше. Поясница вскоре перестанет болеть. (III-18)

ОДНЫ ҮР

Од нь өдөр нэжгээдийг эрхшээх од нь саран өөрийн явдлаар од алинаа оршин орчихуйг ухаж үйлдэхүй (Тооцоолон бодож олохуй, Орч) тэр од бөгөөд ээлжийн нөхөр саран одон болно. Тэр ч одон хорин найм байдаг ч Абизи, Ширван хоёр нэгэн хоногийг эрхшээх [17] тул ээлжийн од нь хорин долоо мөн болой. Тэдгээр од тус, тусын эрхшээх өнийн хэмжээ нь жаран мөч болно. "Зурганд ургасан нь саран од хийгээд барилдлага од хоёр нь өнгөрсөн хэмээн номломуй" гэж зарлигласан болохоор, Үлгэрлэвээс: таван мөч, арван чинлүүр мэт ургахын цагт тэр одны жаран мөчөөс таван мөч, арван чинлүүр нь нөгчсөн ажгуу. Эдүгээ тавин дөрвөн мөч, тавин чинлүүр буй болохоор авч, огоорохын өнийн хэмжээг түүнд шүтэж мэдэх хэрэгтэй болой.

Одны өгүүлэл нь тус, тусын үр хийгээд зүгд эвсүүлсэн хоёр буй.

Анхдугаарт: Тус, тусын өгүүлэл нь:

Ашувани нь дайсны одон, хийн махбодатай болно. Ном номлох, бурхныг тахих, хишиг даллага дуудуулах, хувцас эсгэх, худалдаалах, эм найруулах, худаг малтах, дэлгэрүүлэх хийгээд хатуу үйлд сайн. Их хурал цуглаан хийх, бэр авах, нүүдэл суудал хийх, гадагш өгөхийг тэвч. **Барани** нь буртаг одон, гал махбодатай. Боолыг шүтүүлэх, гал голомтыг үүсгэх, хүрээ давхарлах, мал авах, худалдан авах, хариулга балин гаргах, хатуу үйлд сайн. Үхээр тавих, бэрийг гадагш өгөхийг тэвч.

Гирдиг нь өгүүлэхүйн одон гал махбодатай. Номд

суралцах, шүтээн босгох, бурхныг тахих, нас хийгээд эдийн бүтээл хийх, хурим найр хийх, гэр бүрэх, мал худалдаж авахад сайн. Замд гарах, бэр хийгээд үхэгсэдийн үйл, хөрөнгө тавихыг тэвч.

Ровагини нь хишиг одон, шороон махбодатай. Орон, шүтээнийг шинээр барих, хүрээ барих, нас, эдийн бүтээл хийх, мал авах, эм найруулах, хөрөнгө тавих, гэр бүрэх тэргүүтэн бататгахын үйлд сайн. Хурим найр хийгээд хэрүүл, тэмцэл хийх, бэр авах, үхэгсэдийн үйлийг тэвч.

Мэргэшир нь буртаг одон, хийн махбодатай. Тойн болох, амьлуулах, ном номлох, бурхныг тахих, насны даллага дуудуулах, тариалангийн үйл, бэрийн үйл, дэлгэрүүлэх үйл хийгээд хатуу үйлд сайн. Замд гарах, үхээрийг тавих, нүүдэл суудал хийхийг тэвч.

Артир нь жуулчны одон, усан махбодатай. Амьлуулах, тойн болох, урлахуй хийгээд үсэг, зурхайд суралцах, заргалдах, буг дарах, хөрөнгө талбих, худаг малтах, мал худалдан авах, насны хишиг даллага дуудуулах, үс авахуулах зэрэгт сайн. Бэр, үхэгсэдийн үйл, хувцас эсгэх, замд гарах, нүүдэл суудал хийх, гэрийн бүрээс оёхыг тэвч.

Бурнавасан нь хишиг одон, хийн махбодатай. Ном номлох, сонсох, бурхныг тахих, хишиг даллага дуудуулах, хөрөнгө тавих, хувцас эсгэх, бэр авах, газрын амыг нээх, замд гарах, худалдаан зэрэгт сайн. Хүүр гаргахад дунд зэрэг. Хэрүүл тэмцэл хийх, гадагш эсэргүүцэх зэргийг тэвч.

Бүс нь бүтээлийн одон, гал махбодатай. Хот мандал байгуулах, насан даллага дуудуулах, хувцас эсгэх, үсээ авахуулах, бэрийн үйл хийгээд эм найруулах, мал

авах зэрэгт сайн. Гадагш өгөх, нүүдэл суудал хийх, тариалангийн үйлийг тэвч.

Аслис нь жуулчны одон, усан махбодатай. худалдаа арилжаа хийх, хүрээ хашаа барих, хэрүүл тэмцэл хийх, буг дарах, хатуу үйлнээ сайн. Нүүдэл хийх, эм найруулах, шүтээн босгох, замд гарахыг тэвч.

Мэг нь дайсны одон, гал махбодатай. Төлөг тавих, үсэгт суралцах, шинэ гэр барих, боолыг шүтүүлэх, хөрөнгө талбих, эд авах, хишиг даллага дуудуулах, мал худалдан авах, үс авахуулахад сайн. Замд гарах, нүүдэл судал хийх, бэр авах, хувцас эсгэх, газар малтах, үхэгсэдийн үйлийг тэвч.

Бурбабэлгүни нь буртаг одон, гал махбодатай. Бурхныг тахих, эд мал авах, насан даллага дуудуулах, хариулга балин гаргах, амирлангуй үйлд сайн. Замд гарах, бэр авах, үхэгсэдийн үйл, хувцас эсгэх, хатуу үйлийг тэвч.

Удирабэлгүни нь дайсны одон, хийн махбодатай. Шинэ гэр, орон, шүтээн босгох, номлох, сонсох, бурхныг тахих, хишиг даллага дуудуулах, гэрийн бүрээс оёх, бэр авах, нүүдэл суудал хийх, бататгах үйл зэрэгт сайн. Хувцас эсгэх, худаг малтах, үхээр гаргах, хөрөнгө тавих, замд гарахыг тэвч.

Хасда нь үхээрийн одон, хий махбодатай. Буяны үйл, эм найруулах, хувцас эсгэх, гэр барих, баяр хурим үйлдэх, газрын ам нээх, тариалангийн үйл, үс авахуулах, үсэг зурхайд суралцах тэргүүтэн түргэн бүтээх үйлнээ сайн. Замд гарах, үхээр гаргах, нүүдэл суудал хийхийг тэвч.

Цэдэр нь өгүүлэхүйн одон, хийн махбодатай. Насны даллага дуудуулах, хувцас эсгэх, эм найруулах,

хөрөнгө тавих, хариулга балин гаргахад сайн. Бурхныг тахих, ихэтгэх, замд гарах, үхэгсэдийн үйл, нүүдэл суудал хийхийг тэвч.

Сувади нь хишиг одон, хийн махбодатай. Номлох, сонсох, эм найруулах, насан даллага дуудуулах, бэрийн үйл, шүтээн босгох, замд гарах, худалдаа арилжаанд сайн. Үхээр талбих, нүүдэл суудал хийхийг тэвч.

Шошаг нь бүтээлийн одон, гал махбодатай. Хот мандал зурах, буяны үйл, бэрийн үйл, гэр барих, хувцас өмсөх, эсгэх, тариалангийн үйл, үс авахуулахад сайн. Гадагш өгөх, үхээр талбих, хэл ам гаргах, нүүдэл суудал хийхийг тэвч.

Анурад нь өгүүлэхүйн одон шороон махбодатай. Бурхныг тахих, хишиг даллага дуудуулах, эм айруулах, буяны үйл, тариалангийн үйл, хувцас эсгэх, замд гарах, эд мал авахад сайн. Бэрийн үйл, үхэгсэдийн үйл, гэр бүрэхийг тэвч.

Цэста нь жуулчны одон, шороон махбодатай. Тойн болох, амьлуулах, ихэтгэх, нас, эдийн бүтээл хийх, сургууль хийх, малын үйлд сайн. Хувцас эсгэх, эм найруулах, бэр хийгээд үхэгсэдийн үйлийг тэвч.

Мол нь буртаг одон, усан махбодатай. Шүтээн босгох, нас эдийн бүтээл хийх, худалдаа хийх, нүүдэл суудал хийх, хөрөнгө тавих, боолыг шүтүүлэх, хариулга, балин гаргах тэргүүтэн хатуу үйлнээ сайн. Замд гарах, бэрийн үйл хийгээд үхээр тавихыг тэвч.

Бурвасад нь хишиг одон, усан махбодатай. Нас эдийн бүтээл хийх, нөхөр бололцох, боолыг шүтүүлэх, худалдаа арилжаа хийх, худаг малтах, замд гарах, амьдын үйлд сайн. Гадагш өгөх, үхэгсэдийн үйлийг тэвч.

Удирасад нь бүтээлийн одон, шороон махбодатай. Ном номлох, сонсох, шинэ гэр барих, нөхөр, боолыг шүтүүлэх, хувцас эсгэх, шүтээн босгох, бэр, үхэгсэдийн үйл, нүүдэл суудал хийх, гэрийн бүрээс оёх, амирлангуй, дэлгэрэнгүй, эрхшээх үйлд сайн. Гадагш өгөх, замд гарахыг тэвч.

Абизи нь өгүүлэхүйн одон, шороон махбодатай. Амьлуулах, шүтээн босгох, буяны хийгээд усны үйл, гэр барих, хувцас эсгэх, эм найруулах, замд гарах, худалдаанд сайн. Байшингийн үйл, буг дарахыг тэвч.

Ширван нь үхэгсэдийн одон, шороон махбодатай. Бурхныг тахих, үс авахуулах, насан бүтээл хийлгэх, хөрөнгө тавих, замд гарах, худалдаанд сайн. Хувцас эсгэх, бэрийн үйл, ихэтгэхийг тэвч.

Даниста нь жуулчны одон, усан махбодатай. Бурхныг тахих, хишиг даллага дуудуулах, эм найруулах, суврага босгох, балгадын үйл, гэр барих, хувцас эсгэх, замд гарах, тариалангийн үйлд сайн. Нүүдэл суудал хийх, бэр хийгээд үхэгсэдийн үйлийг тэвч.

Садабис нь хишиг одон, шороон махбодатай. Орон шүтээнийг барих [18], газрын ам нээх, хөрөнгө тавих, замд гарах, дэлгэрэнгүй үйлд сайн. Хувцас эсгэх, үс авахуулах, бэрийн үйлийг тэвч.

Бурвабадрабад нь үхэгсэдийн одон, гал махбодатай. Бурхныг тахих, эм найруулах, мал худалдан авах, боолыг шүтүүлэх, хөрөнгө талбих, үхэгсэдийн ба буяны үйлд сайн. Замд гарах, хувцас эсгэх, бэрийн үйлийг тэвч.

Удирабадрабад нь үхэгсэдийн одон, усан махбодатай. Эм найруулах, замд гарах, боолыг шүтүүлэх, худалдаа, арилжаа хийх, үхэгсэдийн үйл,

хөрөнгө талбих, амирлангуй үйлд сайн. Хишиг даллага дуудуулах, гэрийн бүрээс оёх, бэрийн үйлийг тэвч.

Ривади нь бүтээлийн одон, усан махбодатай. Тойн болох, номлох, сонсох, ихэтгэх, хишиг даллага дуудуулах, эм найруулах, нүүдэл суудал хийх, үс авахуулах, гэр барих, түргэн бүтээхүй үйл зэрэгт сайн. Хувцас эсгэх, замд гарах, гэрийн бүрээс оёхыг тэвч.

Хоёрдугаарт, үйлд сайн муу лугаа тохируулан оддыг нэгэн зүгт эвсүүлэн өгүүлэхүйд, "Нарны гэрэл" (ཉིན་བྱེད་སྣང་བ།) [19] хэмээх сударт:

"**Батгүй болох дөрөв од хэмээх** Бүс, Ашувани, Хасда, Ривадид тахилга, тайлгын зан үйл хийх, ном номлох, санваар хүртэх, дээдэст айлтгал хийх, эд өргөх тэргүүтэн өөрийн хэргийг түргэн бүтээх үйлд сайн. Түүнд хур бууваас гантай болно. Эдгээр одонд төрсөн хүүхэд ная хүрч наслана. Яриа нь дөлгөөн, гоо үзэсгэлэнтэй, гар нь уран, бие, оюун нь тогтворгүй, суух нь үгүй. Өвөрчилөн [20] нь машид муу. Өвдөх нь өчүүхэн бөгөөд хүрсэн даруйд амирлана.

Машид бат дөрвөн од хэмээх Ровагини, Удирабэлгүни, Удирасад, Садабисд шинэ орныг барих, орон, шүтээнийг босгох, түшмэл болох, мод, төмс, ногоог тарих, цэцэрлэгт хүрээлэн (Ногооны хашаа), баясгалангийн хүрээлэн байгуулах тэргүүтэн бат хийгээд өнөд оршоохуй үйлийг үйлд. Тэр үест хур орвол хур олонтоо бууна. Эдгээр одонд төрсөн хүмүүс нь зуу хүрч наслана. Баян хийгээд өглөгт баясагч болно. Өөр бусдад эд баялагийг өгөгч, шударга өгүүлэгч. Өвөрчилөн нь муу ч өвдвөл түргэн эдгэрнэ.

Түргэн сайн дөрвөн од хэмээх Мэргэшир, Цэдэр, Анурад, Удирабадрабадад тариалангийн үйл хийгээд

хувцас чимэг өмсөх, зүүх хийгээд түргэн бүтээх үйлнээ сайн. Түүнд (Тэр одтой өдөр) хур бууваас дахин түргэн бууна. Тэр одонд төрсөн хүмүүн хорин найм буюу ер хүрч наслана. Яриа нь дөлгөөн, оюун нь хурц, гоо үзэсгэлэнтэй, үнэн өгүүлэгч, яруу алдар төгөлдөр, сэтгэл нь тогтворгүй, бусад хүмүүс түүнд баясахуй ба хатуу үгтэй, хориос гучин насны хооронд өвөрчилөн нь муу ч дахин өөрчлөгдөж, машид сайн буянтай болно. Өвдвөл дараалан амирлана.

Муу үрт дөрвөн од хэмээх нь Артир, Аслис, Цэста, Мол болно. Балгадыг дарах, цэрэг хөдөлгөх, алах, хулгайлах тэргүүтэн хатуу үйл хийгээд муу явдалд сайн. Түүнээ хур орвоос хойшид өчүүхэн болно. Тэр одонд төрсөн хүмүүс гуч, тавь, жар, дал хүрч наслана. Сайн үйлийг үл хийгч бөгөөд муу үйлд машид хичээнгүй, үхэхийн хооронд өвөрчилөн муу. Өвдвөл эдгэх нь хялбар.

Түргэнээ урвахуй таван од хэмээх нь Бурнавасан, Сувади, Абизи, Ширван, Даниста бөгөөд хол газар бусдын нутагт одохуй, худалдаа тэргүүтэн бат бус бүхэн, түргэн бүтээхүй үйлийг үйлд. Тэр үест хур бууваас түргэн олонтоо бууна. Түүнээ төрсөн хүмүүс жар хүрч наслана. Сэтгэл нь машид сайн бөгөөд өвөрчилөн янаг найланхай, явдал, хичээлд дуршигч, насан нь ахар богино боловч өвөрчилөнгөөрөө амирлах болой. Худал өгүүлэгч, өвөрчилөн муутай нэгэн болно.

Бат хэрэг бүтээгч таван од хэмээх нь Мэг, Бурбабэлгүни, Барани, Бурбасад, Бурбабадрабад бөгөөд амраг нөхөр бололцох, худалдаа, арилжаа хийх, нөхрийг шүтэх, байшингийн суурь тавих, абшиг эрх өгөх, амьлуулах, өглөгийн түллэг хийгээд урлахуй

үйл, буяны үйлд сайн. Түүнд хур бууваас дахин, дахин бууна. Тэдгээр одонд төрсөн хүмүүн ерэн тав хүрнэ. Урлахуй ухааныг үйлдэгч, мэргэн хийгээд үхэхийн хооронд өөрчилөн муу. Өвдвөл гэм үл болно. Энэ хүмүүнтэй Барани одны үр нь харшлах шалтгаан ихтэй тул шинжилж үйлдээрэй.

Тэгшид үйлдэгч хоёр од хэмээх нь Гирдиг, Шошаг хоёр бөгөөд түүнд тус хэрэгтэй үйлс тэгшидэн одох тул нэн сайн. Таван эрдэнэ хийгээд шороооны урлал, урлахуй ухааны үйл, өглөгийн түллэг [21] зэрэгт сайн. Тэр хоёр одонд төрсөн хүмүүн насны эхэнд муу ч насны адагт сайн болно. Өвдвөл эдгэх нь хялбар" хэмээсэн болой.

"Эрдэнийн эрих (རིན་ཆེན་ཕྲེང་བ)" [22] гэдэг судART: "2, 13, 16, 21

(Абизи) өгүүлэгч дөрвөн одонд буян номыг үйлд. 3, 6, 14, 19, 23 хишиг таван одонд эдийг бүү хэмж(үнэл). 4, 10, 18, 1 буртаг дөрвөн одонд алин ч муу. 5, 8, 17, 22 жуулчны дөрвөн одонд замд гар. 7, 15, 20, 26 бүтээл дөрвөн одонд алиныг хийсэн сайн. 12, 21 (Ширван), 24, 25 үхэгсэдийн дөрвөн одонд үхэгсэдийн үйлийг үйлд. 9, 11, 15, 0 дайсан дөрвөн одонд дайсантай тэмц" хэмээсэн болой.

БАРИЛДЛАГЫН ҮР

Барилдлага (Учрал) нь наран од, саран од хоёрын мөч, чинлүүр тэргүүтнийг нэмсэн өнөд агуулагдах болой. Тэр ч үлгэрлэвээс наран одны мөч арав, саран одны мөч тав мэт ургахын үест барилдлагад арван таван мөч гарах болой. Түүнд барилдлага бүхэн 60 мөчийг эрхшээх бөгөөд зурганд ургасан нь нөгчсөн эдэлбэр мөн болохоор 15 мөч нөгчсөн байна. Тэр мэт 45 мөчийн хооронд эрхшээх болохоор түүний авч, огоорохыг мөчд шүтэж ухаж ойлгох хэрэгтэй.Үр нь "Нарны гэрэл" гэдэг судрт: "Түүнд сайн, муу зүг лүгээ эвсүүлсэн нь: арилгах, маш хавдагч, эвэршээл, хавдагч, хотлыг дарагч, очир хийгээд машид унагч, огоот дарагч хийгээд өслөгч ес нь муу бөлгөө. Үлдсэн арван найм нь сайн" хэмээн номлосон буй. Сайн нь буяны, муу нь хилэнцтэй үйлд өлзийтэй. Есийн өөр, өөрийн хүрэх завсраас эхлээд тэвчигдэхүүн мөчний тоо нь арилгахын гурав, эвэршээлийн тав, хавдагч хийгээд машид хавдагчийн зургаа, огоот дарагч, очирын есөн мөч, машид унагч, огоот дарагч, өслөгч гурван мөч муу болохоор мөчний тоо бүхнийг тэвч.

Ялгамжтайд (Өвөрмөцд) тус, тусын авч, огоорох нь: "Арилгахуйд замыг арилгахад сайн. Амрагт бүхэн лүгээ амраг болюу. Насан төгсөд насан урт, цогийг олох болой. Хувь сайтад хотол чуулган болно. Сайнд бүгд сэтгэлд зохистой болно. Машид хавдагчд эд, мал барагдюу. Сайн үйлд хойтын элдэв зам төгсөнө. Баригчид эд, эдэлбэр олдюу. Эвэршээлд хэргийг

Карпо (4-349)

Нге

үйлдвэл хорлол их болно. Хавдагчид лусын өвчин хөдлөх болно. Арвижихуйд эд, идээ арвижна гэж номлосон буй. Магадад дайсныг ноттой дарна. Бүхнийг дарагчд хулгана яр хөдөлмүй. Баясгаланд дунд агаад ихэд баясгалантай болно. Очирд хүсэл бүхнийг дарюу. Шид бүтээлд юу санасан бүтэх болой. Машид унагчд хагацан одохуй муу. Дээдтэнд дайснаас ялах болно. Огоот дарагчд гянданд хүлэгдэх болно. Амирлангуйд үр магадтай шагнана. Бүтсэнд санасан бүгд бүтюү. Бүтээгдэхүүнд арилжаанд явахуй сайн. Буянаа амьдын хуримыг үйлдэх сайн. Цагаанд явах, суухуйд сайн. Асарт тэнгэрийн хутгийг олюу. Эрхэтд сургуулийг үйлдэхүйд сайн. Өслөгчид бүсгүй амраг лугаа хагацюу" хэмээсэн болой.

Арилгахуй(–)=Сел Амраг=Дзаво Насан=Цедэн Хувь сайн=
N4 Калзанг Сайн=Зангпо(Самбу) Шинпан=Машид хавдагч
Лезан=Сайн үйл Дзин=Баригч; Эвэршээл=Зер (Хагацахуй)
Хавдагч=Дре Арвижих=Пхел (11) Магад=Нге Кундагом=
Бүхнийг дарагч; Баясгалан=Га; Очир=Дордже; Нгодруб=
Шид бүтээл (16) Машид унагч=Кунтун (!); Паво=Дээдтэн
Огоот дарагч=Йондгом; Цива=Амирлангуй (20)
Бүтсэн=Друб; Бүтээгдэх=Друбджее Буян=Ге
Карпо=Цагаан; Вангпо=(25)=Асар Эрхэт=Цанг
Шакон=Өслөгч

Кунтун=N17=Машид унагч

ҮЙЛДЭГЧИЙН ҮР

Үйлдэгч нь шинийн хоногийн эдэлбэрд дулдуйдаж агуулагдах болой. Тэр ч тэр эдэлбэрд хоёр ангид үйлдэж, урд хувьд нэг үйлдэгч, хойт хувьд бас нэг үйлдэгч эрхшээх мөн болой. Тэндээс шинийн нэгний урд хувь ба хорин есний хойт хувь, битүүний урд, хойт хоёр бөгөөд дөрөвд үл юүлэхийн үйлдэгч дөрөв эрхшээх ба шинийн нэгний хойт хувиас хорин есний урд хувийн хоронд юүлэн үйлдэгч долоо нэжгээдээр эрхшээн үйлдэх болой. Тэр ч онохуйд хялбар болохын тухайд хүснэгтэд байгуулсан нь энэ мэт.

11 үйлдэгчийн хүснэгт	Үзэш үгүй	Өлзий	Замын дөрвөлжин бэлчир	Сайн лус	Таригч	Нялх
Өдрийн тоо, урд хувь	1		30		5 12 19 26	2 9 16 23
Өдрийн тоо, хойт хувь		29		30	1 8 15 22	5 12 19 26

11 үйлдэгчийн хүснэгт	Буян	Гүнчэд нүдэгч	Гэрээс төрсөн	Худал-дагч	Висди
Өдрийн тоо, урд хувь	6 13 20 23	3 10 17 24	7 14 21 28	4 11 18 25	8 15 22 29
Өд-рийн тоо хойт хувь	2 9 16 23	6 13 20 27	3 10 17 24	7 14 21 28	4 11 18 25

Үр нь: “Нарны гэрэл“ судраас:

"Юүлэн үйлдэгч долоогийн үр нь:

Тарихчид эм найруулах, дэлгэрүүлэх үйл, буян хийгээд бат, хөдөлгөхүй үйл, номын явдал болон марган мэтгэлцэх, тогтоол урихд сайн.

Нялхад түшмэлийг өргөн хүндлэх тэргүүтэн өлмийг бататгах ба тойн болох, эмх журам тогтоох зэрэг бярманы үйл, эцэг, эхийн хэрэг ба өглөгийн түллэг, үхрийн үйлд сайн.

Буянд өөр, бусдын үйл бүхнийг бүтээх хийгээд ялангуяа лагшин хөргийг бүтээн босгох (Бурхан бүтээх), амьлуулах тэргүүтэн үл хөдлөхүй бататгахын бүхий л үйл, марган мэтгэлцэх, худалдаа арилжаа хийх, эрхшээх үйл, эд эдэлбэрийг нүүлгэн шилжүүлэх зэрэгт сайн.

Гүнчэдийг нүдэгчид эрхэндээ хураах, өлзий хутгийн тахил өргөх, эрхшээх ба дэлгэрүүлэх үйл бүхнээ өлзийтэй сайн.

Гэрээс төрсөнд тариалангийн үйл хийгээд гэр барих тэргүүтэн үйл бүхнээ сайн.

Худалдагчид худалдаа, арилжаа хийх, бататган үйлдэх үйлд сайн.

Висдийд бусдыг хороох, хор найруулах, хатуу үйлийг үйлд. Буяны үйл ба абшиг эрх өгөх, амьлуулах, хэрэг тусыг бүтээх, бэрийн үйл тэргүүтэнд муу. Хатуу үйлд сайн ч хэл ам гаргахыг тэвч.

Мөнхөд үйлдэгч дөрвийн үр нь:

Өлзийд эм найруулах, тогтоол тоолох, хараал хийх, дэлгэрүүлэх үйлд сайн.

Замын дөрвөлжин бэлчирт бярманыг тахих, хан төрийн үйл, үхрийн үйл хийгээд онгодын цацал тэргүүтэн үйлд сайн. Лусд тушаах, барагдуулах үйл, садныг салгах, ховлох үйлд сайн.

Үзэш үгүйд буяны үйл хийгээд нууцлах, захидал харилцах, хувь сайтын үйл, илт хүслийг дэлгэрүүлэх үйл, абшиг эрх өгөх зэрэгт сайн" хэмээсэн болой.

Сайн лус - информация,
- Висди - молчание
Ещё один заговор на богатство:
В ночь на Ивана Купалу обваляйтесь в росе
среди полевой травы. Шепчите при этом
так: „Как все травки-муравки никто не считает,
Счёту вашего никогда не узнает,
Так чтобы и я, Божий раб (имя),
Не знал счёту своему богатству.
Во имя Отца и Сына и Святого Духа
Ныне и присно и во веки веков.
Аминь." [N16 стр. 60.

МАХБОДЫН БАРИЛДЛАГЫН ҮР

Барилдлага, тохирлогыг дөрөв ялган өгүүлнэ.

Анхдугаарт, Махбодын барилдлагыг өгүүлмүй. Одон зурхайн гараг, одны махбодыг хүснэгтэд байгуулсан нь:

6	0	Шороо	3	16	17	20	21	21	23
2	4	ус	5	8	18	19	22	25	26
1	3	гал	1	2	7	9	10	15	24
5	8	хий	0	4	6	11	12	13	14

Хоёрдугаарт, Үр нь:

Хоёр шороо учирсан шидийн барилдлага. Шидийн барилдлагатай өдөр юу санасан хэрэг бүтнэ. Шүтээн босгох, балгадыг босгох, тариалан тарих, худалдаа хийх, дэлгэрүүлэх үйлд хичээх хийгээд зөвших тэргүүтэн бататгах үйлд сайн.

Хоёр ус учирсан рашааны барилдлага. Рашааны барилдлагаар насны хүчийг арвитгах, эм найруулах, угаал үйлдэх, бэр авах, насны абшиг, насан бүтээлийн зан үйл хийгээд ураг садан бололцох, худалдааг үсгэх, арвижуулах үйлд сайн.

Шороо, ус учирсан **идэрийн барилдлага**. Идэрийн барилдлагатай өдөр машид жаргах, баяр хурим хийх, их хэргэм зүүх, хувцас өмсөх, чимэг зүүх, бүжиг, наадгай хийх зэрэгт сайн.

Хоёр гал учирсан арвидахын барилдлага. Арвидахын барилдлагатай өдөр идээ, хувцас олох, худалдааны үйл,

өглөг өгөх, хөрөнгө тавих, эдийн үргэлжлэлийг бүтээх, усан өглөг өргөх, эдийн тэнгэрийг тахих, шид бүтээлийг өчин айлтгахад сайн.

Хоёр хий учирсан хотол чуулганы барилдлага. Хотол чуулганы барилдлагтай өдөр санасан хэрэг түргэн бүтнэ. Жуулчлалыг хийх, тус хэрэгт үйлийг хийх, хэл амыг боох, арга заль гаргах, хатуу хийгээд түргэн бүтээх үйлд сайн.

Гал, хий учирсан хүчин төгсөхийн барилдлага. Хүчин төгсөхийн барилдлагатай өдөр өлзий хутгийг үйлдэх, гүрэм засал хийх, бурхныг тахих, номын явдлыг үйлдэх, амирлангуй, дэлгэрэнгүй, эрхшээх үйл бүтмүй.

Шороо, хий учирсан үл тохирохын барилдлага. Үл тохирохын барилдлагатай өдөр идээ, эдлэл барагдах, хулгай, дээрэм, булаалга гарах тэргүүтэн гаслан ирнэ. Хэрэг үл бүтэх болой.

Ус, хий учирсан үл зохилдохын барилдлага. Үл зохилдохын барилдлагатай өдөр амраг, садныг салгах хийгээд ховлох, дайсныг хөөх үйлд сайн.

Шороо, гал учирсан түлэхийн барилдлага. Түлэхийн барилдлагатай өдөр зовлон үүсгэх, цэрэг хөдөлгөх, дайсныг дарах, хатуу үйл, тэмцэлдэх, чанадад зовлон үүсгэх бүхнийг үйлд.

Гал ус учирсан үхэхийн барилдлага. Үхэхийн барилдлагатай өдөр амийг булаан үйлдэх, чанадыг алах, хор найруулах, хараал хийх тэргүүтнийг ухаанаар бүтээ.

Үүнд: Сайн гурав, сэргээн чадах гурав, муу гурав, адгийг нэг лүгээ арван барилдлага буй. Эдгээр нь ажил үйл бүхэнд сайн, муу нөлөөг үзүүлэх болой.

“Гараг, од нь тус бүр сайн боловч учрал муу бол

түүний үр боловсроно. Гараг, одон түүнээс буцахын цагт барилдлага нь сайн болвоос түүний үр нь бүтнэ. Түүний тулд учралыг эрхэм болгон зохио" хэмээсэн болой.

Хоёдугаарт, Их тохирлогыг хоёр ялган өгүүлнэ.

Анхдугаарт, Зургаар нотлон буулгахын ёс нь: "Тэр өдрийн ээлжийн гарагийг хоёр оронд байгуул. Доодоос дүрсийг(нэгийг) хасч, махбодоор (тав) хувил(үржүүл), дээдэд Абизи, Ширван хоёрыг тус, тусд нь ялгасан саран одоор чимж(нэмж) доод чуулганаар хас, хасч эс хүрвээс лус гарыг (28-ыг) нэмсэнээс хас. Үлдэгдэлд нэг ургаваас Хотол баясгалан бөлгөө. Түүнчлэн үйлдээд тоол" хэмээсэн болой.

Хоёрдугаарт, Үр лүгээ нь хамт хүснэгтэд байгуулсан нь:

12 июня 2014г

Ад	Су	Ан	Бу	Ба	Су	Са	Гараг одны их тохирлого
0	4	8	12	16	20	23	Хотол баясгаланд эдийг олох болно.
1	5	9	13	17	21	24	Цагийн шийдэмд аюул ирнэ.
2	6	10	14	18	21	25	Номхонд эд элбэг, баялаг болно.
3	7	11	15	19	22	26	Есөн төрөлхтөнд бүхий л төрөлхтөн амгалан болно.
4	8	12	16	20	23	0	Залууд үйл бүхэн амар хялбар бүтнэ.
5	9	13	17	21	24	1	Хэрээд хэл ам болно, айн эмээмүй.
6	10	14	18	21	25	2	Дуацд хувцас хийгээд эд олдно.

Ад	Су	Ан	Бу	Ба	Су	Са	Гараг одны их тохирлого
7	11	15	19	22	26	3	Цогийн зурхайд их эрдэнэ хурааюу.
8	12	16	20	23	0	4	Очирд цахилгаан буухын аюул болмуй.
9	13	17	21	24	1	5	Алханд үхлийн аюул болмуй.
10	14	18	21	25	2	6	Шүхэрт дайсныг номхруулах болно.
11	15	19	22	26	3	7	Нөхөрд нөхөртэйгээ учирмуй.
12	16	20	23	0	4	8	Сэтгэлд цогийг олох болой.
13	17	21	24	1	5	9	Хүслийн хаанд сэтгэлийн ерөөл бүтмүй.

Ад	Су	Ан	Бу	БА	Су	Са	Гараг одны их тохирлого
14	18	21	25	2	6	10	Цучилын галд хэрүүл, тэмцэл ирнэ.
15	19	22	26	3	7	11	Үндэс сугалахуйд наснаас хагацах болно.
16	20	23	0	4	8	12	Үхлийн эзэнд үхэл болюу.
17	21	24	1	5	9	13	Сумд хамар хийгээд гишүүн доройтно.
18	21	25	2	6	10	14	Шидэд үйл алиныг бүтээхнээн ч бүтмүй.
19	22	26	3	7	11	15	Жадад өвчний аюул ирмүй.
20	23	0	4	8	12	16	Рашаанд дайсан хөдөлмүй.

Ад	Су	Ан	Бу	БА	Су	Са	Гараг одны их тохирлого
21	24	1	5	9	13	17	Нүдүүрд тархи хагарахын аюул ирмүй.
21	25	2	6	10	14	18	Заанд хэрэг бүхэн бүтмүй.
22	26	3	7	11	15	19	Насад согтохуйд унаа олмуй.
23	0	4	8	12	16	20	Барагдахуйд эдээс хагацюу.
24	1	5	9	13	17	21	Хөдлөхүйд ажил даяараа бүтмүй.
25	2	6	10	14	18	21	Батад орчлонгийн үйл доройтмуй.
26	3	7	11	15	19	22	Арвидахуйд эд бараа арвидмуй.

Гуравдугаарт: 14 түлэхүй тохиолт өдөр; Эрлэг, гэм, үхэх хэмээх гурван барилдлага хийгээд сайн дөрвөн үйлийн барилдлагуудыг үр лүгээ сэлт нь байгуулбал:

Гарагийн нэр	Ад	Сум	Ан	Бу	Ба	Суг	Са
Сарын шинэдийн өдөр	12	11	10	3	6	2	7
Сарын хуучдын өдөр	27	26	25	18	21	17	22

Гараг одны түлэхүй тохиолт өдөр бөгөөд цагаан зүгийн буяны үйл, ханиур, төөнүүрийг тэвч. Буян алныг үйлдсэн ч үр үгүй. Хэв торго шатан үнс болох мэт хэмээн номложээ.

Эрлэг, гэм, үхэх хэмээх гурван барилдлага

Өдөр	гараг	од	Тэр гурав нь Доржхандын ёс.
13	5	8	Гэм бүхэн гарна хэмээн тэвч.
29	6	1	Эрлэгийн соёо мөний тул тэвч.
15	0	9	Үхлийн их барилдлага хэмээн ихэд муу.

Сайн дөрвөн үйлийн барилдлага

Ад	Су	Ан	Бу	Ба	Суг	Са
7	8	2	3	4	5	6
14	15	16	17	18	19	20
21	21	22	23	24	25	26
0	1	9	10	11	12	13

Өөр, өөрийн эзэн гараг, одны дээр нүүрс, утаа, тэврэлт гурав тэргүүтэн гэм олныг барьдаг ч хорлол үгүй ба буяны үрийг шагнана. Үүнийг сайн дөрвөн үйлийн барилдлага хэмээн номлосон буй.

Дөрөвдүгээрт, Адъяа, Хасдагийн шид барилдлага тэргүүтнийг хоёр зүйлээр өгүүлэх болой.

Анхдугаарт,

Барилдлагуудыг хүснэгтэд байгуулсан нь:

Гараг одны барилдлага	Шид барилдлага	Хос барилдлага	Шимунасыг ялгуусан	Бүтээл өдөр хоёр ёсны нэгэн	Бүтээл өдөр хоёр ёсны нэгэн
1	12	9	18	18	19
2	21	15	21	22	13
3	0	5	25	25	25
4	16	18	2	2	2
5	7	11	6	7	6
6	26	3	10	10	10
0	3	19	14	15	14

Гараг одны барилдлага	Өлзий хутгийн өдөр хоёр ёсны нэгэн	Өлзий хутгийн өдөр хоёр ёсны нэгэн	Арвидах өдөр адил үгүй хоёр ын нэгэн	Арвидах өдөр адил үгүй хоёрын нэгэн	Онох өдөр
1	25	25	3	3	9
2	13	8	14	19	15
3	14	10	7	6	5
4	17	17	16	16	18
5	11	11	25	25	24
6	2	2	4	4	3
0	3	14	24	22	19

Гараг одны барилдлага	Ивээл өдөр	Барилдлага өдөр адил үгүй хоёрын нэгэн	Барилдлага өдөр адил үгүй хоёрын нэгэн	Шимунас өдөр	Үл тохирох өдөр адил үгүй хоёрын нэгэн
1	17	4	4	2	22
2	25	17	17	11	15
3	24	2	2	8	16
4	1	19	1	19	19
5	0	23	22	4	21
6	9	0	11	7	3
0	26	12	17	23	10

Гараг Одны Барилдлага	Үл тохирох өдөр адил үгүй хоёрын нэгэн	Ивээл бус өдөр адил үгүй гурвын нэг	Ивээл бус өдөр адил үгүй гурвын хоёр	Аймшигт өдөр адил үгүй гурвын нэг	Аймшигт өдөр адил үгүй гурвын хоёр
1	21	17	23	15	24
2	16	25	25	17	3
3	16	24	0	26	24 23
4	18	1	1	12	13
5	23	16	15 16	3	3
6	3	9	9	6	10
0	10	26	13	1	8

Гараг Одны Барилдлага	Үхэх барилдлага	Түлэхүй өдөр	Очир аймаг савын бүтээл өдөр дөрвийн нэг	Очир аймаг савын бүтээл өдөр дөрвийн нэг	Очир аймаг савын бүтээл өдөр дөрвийн нэг
1	16	9	24	25	26
2	2	15	21	21	21
3	23	5	25	25	26

4	0	18	2	2	2
5	4	22	6	6	6
6	3	3	21	21	21
0	12	19	21	21	21

Очир Аймаг Савын бүтээл өдөр дөрвийн нэг	Очир аймаг савын шимунас өдөр дөрвийн нэг	Очир аймаг савын шимунас өдөр дөрвийн нэг	Очир аймаг савын шимунас өдөр дөрвийн нэг	Очир аймаг савын шимунас өдөр дөрвийн нэг	Ивээл бус өдөр адил үгүй дөрвийн нэг
20	16	16	16	1	9
3	9	19	20	5	15
2	20	20	22	15	1
23	0	0	0	4	1
7	4	4	4	15	15
0	8	8	8	26	9
21	11	11	11	12	13

Гараг одны барилдлага	Ивээл бус өдөр адил үгүй дөрвийн нэг	Ивээл бус өдөр адил үгүй дөрвийн нэг	Ивээл бус өдөр адил үгүй дөрвийн нэг	Аймшигт өдөр адил үгүй дөрвийн нэг	Аймшигт өдөр адил үгүй дөрвийн нэг
1	17	18	23	15	15
2	15	21	25	3	3
3	0	24	5	23	23
4	1	1	1	3	13
5	15	15	16	3	3
6	9	9	9	3	3
0	13	13	16	8	8

Гараг одны барилдлага	Аймшигт өдөр адил үгүй дөрвийн нэг	Аймшигт өдөр адил үгүй дөрвийн нэг	Үл тохирох өдөр адил үгүй гурвын нэг	Үл тохирох өдөр адил үгүй гурвын нэг	Үл тохирох өдөр адил үгүй гурвын нэг
1	19	24	9	21	22
2	20	23	5	15	16
3	23	24	5	16	18
4	18	26	18	18	18
5	3	18	21	23	26
6	6	10	3	3	3
0	19	20	10	19	20

Хоёрдугаарт, Барилдлагуудын үр нь:

Шид барилдлага, рашааны барилдлагатай өдөр үйлдсэн үйл аль нь ч бүтэх сайн.

Хос барилдлагатай өдөр хатуу үйлээс бусад амирлангуй, эрхшээх, дэлгэрүүлэх үйлд буянтай.

Шимунасыг ялгуусан барилдлагтай өдөр бурхныг тахих, дайсантай тэмцэлдэх тэргүүтэн ширүүн, хатуу үйлд сайн. Бүтээл өдөрт хэрэгтэй үйл, буяны үйлд сайн, харин хилэнцтэй үйлд муу.

Өлзий хутгийн өдөрт амгалан, жаргалан үүсгэх, абшиг эрх өгөх, амьлуулах, бурхныг тахихад сайн.

Арвидах өдөрт буяны үйл, үсэг, зурхай, эрдмийг арвижуулах, хур оруулах, худаг малтах, тариалангийн үйл, хөрөнгө талбих тэргүүтнээ сайн.

Онохуй өдөрт сайн үйлс зонхид сайн. Ивээл өдөрт эвсэх, садны ач хариулах, тус хэрэгт сайн. Барилдлага өдөрт бурхныг тахих, буяныг арвижуулахыг хүсэхүй, дэлгэрүүлэх үйлд сайн, гутан доройтуулах үйлд муу. Шимунас өдөрт бэр, үхэгсэдийн үйл хийгээд

Астматический бронхит с удушьем
V-37-38.
Хамб гэнзэла

замд гарахад муу, хараал хийхэд сайн. Үл тохирох өдөрт дайсныг номхотгох, салгах тэргүүтэнд сайн, зохилдуулан барилдуулах, бэр, үхэгсэдийн үйлийг тэвч.

13 **Үл зохилдох өдөрт** салгах үйл тэргүүтэн муу үйлд зохимжтой, сайн үйлийг тэвч. Хариугана

14 **Аймшигт өдөрт** мууг үйлдэхүйд тохиромжтой. Бэр, үхэгсэд, замын үйлийг тэвч. Среда X 26.

15 **Үхэхийн барилдлагад** амьлуулах, насан бүтээл хийгээд балгадын үйл, бэрийн үйл, замд гарахад муу.

16 **Түлэхүй өдөрт**, барилдлага хийх буюу ноттой үйлийг тэвч хэмээн алдаршсан амой. Тус хэрэгт үйл ба ханyур, төөнүүрийг тэвч.

...Я научу вас, как можно избавиться от этого заболевания...
Вскипятите 2 стакана свежего цельного молока. Добавьте в него 2 ч.л. гусиного жира, 1/2 ч.л. бараньего жира и 1/2 ч.л. медвежьего жира. Выпейте всё за полчаса до сна маленькими глоточками, а ещё через 10 минут выпейте 1 десертную ложку отвара корня валерианы. Одной недели бывает достаточно..., но прерывать начатое лечение не следует ещё как минимум 3 недели.
М.Ж. продают ч/з газету, см. объявления.
Пить молоко следует горячим и после этого не выходить из дому, чтобы не простудиться.

ЧУХАЛ ХЭРЭГТЭЙ ЗАРИМ НЭГНИЙ ҮР

Даруйд хэрэгтэй зарим нэгнийг ухахуйд хялбар таван зүйлээр өгүүлнэ. Үүнд: Өдөр хоногт ургасан **бар, туулай тэргүүтэн арван өдөр зэргийн үрийн зурхай;** Сүлд тэргүүтэн **гараг, од;** Сүлдний орон тэргүүтэн; Газрын эзний гүйдэл; **Бэрийн зурхайн аймгийг өгүүлэх** болой.

Анхдугаарт, **12 өдрийн үрийг өгүүлэхүйд** хоёр. Тус, тусын авч, огоорохуй хийгээд өнцөг долоод эвсүүлсний үр болой.

Анх нь, "Нарны гэрэл" сударт: "**Бар өдөр** амьлуулах, өглөгийн түллэг, хишиг дуудуулах, балгадын үйл, дээвэр тавих, цэрэг хөдөлгөх, алах тэргүүтэн хатуу үйлд сайн. Бурхныг тахих, хулгай дээрэм хийх, эм, угаал, амраг садан болох, абшиг эрх өгөх, золиг гаргах, бомбын үйлд муу.

Туулай өдөр үхэр, хонины үйл хийгээд өчих, залбирах, хан орыг барихад сайн. Цэрэг хийгээд балгадын үйл, нөхөр садан бололцох, газар малтах, чулуу ховхлох, цөөрөм, суваг татах, модны үйл хийгээд хишиг дуудуулах, найр хурим, хөрөнгө талбих, газар хагалах, усны хашаа зөөх, ус булагийн эх малтах, хурал цуглаан хийхийг тэвч.

Луу өдөр буяны үйл, мөндөр аянга буулгах, бурхныг тахих, хатуу үйл хийгээд дайсан, зэтгэрийг номхотгох, нутаг орныг булаах, үзмэр үзэх, хэнгэрэг бүрэхэд сайн. Онгоц тавих, гүүр тавих, тээрэм урлах, ханууp, төөнүүр хийх, газар малтах, хүүр гаргах, гаслан гашуудахад муу.

Могой өдөр мал гаргах, лусын зан үйл хийгээд өвчтөнийг(гэрээс) гаргах, угтах, үдэх, цэргийн үйл, өр өгөхөд сайн. Хар мод таслах, удирдан хөтлөх, эм шинжлэх, үхэгсэдийн үйл, хан хийгээд бомба лугаа өсөрхөх, ус хаах, бэр өгөх, авах, хом шатаах, дарах, түрэм хийх, худалдаа, арилжаа хийгээд хан оронд суух, гал голомт үүсгэх, газрын ам нээх, эд өгөх, хатуу үйлд муу. Гаслан гашуудваас үхээрийн гэм ирнэ.

Морь өдөр нууц зөвлөлгөөн хийх, бурхныг тахих, нөхрийг эрэх, хан оронд суух, тангараг, цагаан зүгийн үйлд сайн. Байшин, гэр бүрэх, хэрүүл тэмцэл хийх, бэрийн үйл ба заргалдах, морь худалдан авах, арилжих, тус хэрэгт үйлийг хийх, ёгтлон ярих, үхэгсэдийн үйлд муу.

Хонь өдөр бурхныг тахих, хонь мал авах, балгадын үйл, малыг түгээх, газар малтах, бэрийн үйл, идээ олох, хурим хийхэд сайн. Сахил санваар авах, хануур, төөнүүр хийх, цаг мөчийг шинжлэх, эм найруулах, цэрэг нүүлгэн шилжүүлэх, тус хэрэгтэй үйлд муу.

Бич өдөр бэр авах, мод суулгах, цэцгийн хүрээ байгуулах, чимэг зүүх, бүжиг надгай хийх, дарцаг хийсгэх, дээрэм тонуулыг дарахад сайн. Шинэ хувцас эсгэх, өмсөх, урлахуй ухаан хийгээд гэрийн бүрээс оёх, бэлэг өгөх, эрийн зэвсэг (хувцас) оруулах, зөвлөлгөөн эвсэлдээн хийхэд муу тул тэвч.

Тахиа өдөр өвчтөнд эм засал хийвээс рашаан болно. Мод суулгах, худалдаа арилжаа, тус хэрэгт үйлд сайн. Нууц зөвлөлдөөн хийх, хурим найр хийх, буяны үйл, өглөг өгөх, дарах, үзмэрт муу.

Нохой өдөр хөвгүүн тэжээх, урлахуй ухаанд суралцах, хурал цуглаан хийх, заргалдах, залбирал

тавих, хом шатаах, гөрөө анд одохуйд сайн. Бэр авах, тус хэргийг бүтээх, нүүдэл суудал хийх, нууц зөвлөлгөөн хийх, дэмий ярих, хулгай, булаал, хэрүүл тэмцэл, үс угаахуйд муу.

Гахай өдөр абшиг эш өгөх, ном номлох, хурим найр хийх, нялхасын хурим хийх, тойн болохуйд сайн. Үхээр талбих, малтах, ховхлох, зураг зурахуй, бомбын зан үйл, балгадын үйл хийгээд газрын ам нээхүй, дарахуй, худаг малтахуйд муу.

Хулгана өдөр үүдийг нээх, хулгай, дээрэм ба худалдаа арилжаа, тус хэрэгт үйл, дэмий чалчих, нахилай хөвгүүн [23] авах, нялхсыг тэжээх, эхнэрийг булаахуйд сайн. Улааны үйл, хөвгүүн охин авах, төлөг тавих, морь уралдах тэргүүтэнд муу.

Үхэр өдөр мал худалдах, балгад босгох, хутга урлах, дархны үйл ба заргалдахад сайн. Худалдаа, арилжаа, ухаанд суралцах, бэр авах, арвайн сангийн ам нээхэд муу" хэмээсэн болой.

Хоёрдугаарт, "Энэ өдрүүдээс бар, бич хоёрт зөвлөгөөн, зээлийг тэвч. Тахиа, туулай хоёрт үзмэр үзэхийг тэвч. Нохой, луу хоёрт цэрэг, дээрмийг тэвч. Гахай, могой хоёрт мод ба газар малтахыг тэвч. Хулгана, морьд морь уралдах, улай алахуй үйлийг тэвч. Үхэр, хонь хоёрт ширээ засах, дарцаг хийсгэхийг тэвч" хэмээсэн болой.

Түүний дашрамд нангиадын **12 цагийн үрийг** номлохуйд " Цагаан бэндэръяа" [24] судраас:

"**Туулай** цагт архи, тараг бүрэх, хөлчний амыг боохуйд сайн.

Нар ургах луу цагт хишиг даллага дуудуул.

Нар хөөрөх могой цагт газрын эзнийг номхотгох,

тарни тоолоход сайн.

Бага үдийн **морин цагт** гадагш хариулах, хатуу хариулгад өлзийтэй.

Үд хэвийх **хонь цагт** галзуу хийгээд муужирсныг сэргээх үйлд өлзийтэй.

Нар гудайх **бичин цагт** харшлах, үлдэх үйлд өлзийтэй.

Нар жаргах **тахиа цагт** сахиусны хангал хийгээд тахихуй үйлд сайн.

Газар борлох **нохой цаг** буухын үед харамч бод [25]-ын ам боох үйлд өлзийтэй.

Харанхуй бүрэнхийн **гахай цагт** эм адыг номхотгох үйлд өлзийтэй.

Шөнө дундын **хулгана цаг** ургахын үест хишиг даллага дуудуулах, тарни тоолохуйд сайн.

Шөнө дунд хэвийх **үхэр цагт** хатуу тарнийг бүтээ. Бар цагт дайсныг хороох, тарни удирдахуйд сайн. Өөр ямагтын жилтэй адил цаг болох үест хатуу, ширүүн үйл хийгээд хурал цуглаан, тусгах тулгах, их сүрийг үзүүлэхийг тэвч. Бас бус “Малтах нүх“ буюу “4 шимунас гүйхүй“ цаг нь ширүүн. Хэвийх хоёр хэмээх хоёр, дөрөвд хариулга хийгээд хатуу үйлээс бусад үйл алин ч өлзий бус болой. Цаг хурц мэс [26] мөн болой” хэмээн номлосон бөлгөө.

Хоёрдугаарт, Найман хөлөл [27] өдөрт ургасны үр нь:

Ли-д төмөр, шаварыг цутгах, өгөх, чимэг түгээх, онгодыг тахих, хом шатаахад сайн. Зохилдох, найрамдах, бэрийн үйл, цэргийн үйл хийгээд хулгай, дээрэм, үхээрийн үйлд муу.

Хон-д газрын амыг боох, мод хатгах, сүүлийг таслах, буг дарахад сайн. Байшингийн суурь тавих,

өслөн одохуй, үхээр дарах, зөвлөлдөх, угаал, залбиралд муу.

Да-д мод таслах, дорно одохуй, тангаргийг хаах, хулгай дээрэмд сайн. Хөвгүүнийг хөлд оруулах, уяман [28]-ы хүүр түлэх, цэрэг удирдах тэргүүтнээ муу тул тэвч.

Хэн-д огторгуйн үүдийг боох, хан адын хариулга, их хүмүүнтэй уулзах, буяны үйлд сайн. Өвчтөнийг анх гадагш гаргах, сүм байгуулах, балгадын суурь тавих, дээвэр тавих, нүүдэл суудал хийх ба нохой худалдах, худалдан авах зэрэгт муу.

Хам-д бурхан, лусыг тахих, мөндөр буулгах, хариулга хийх, төмөр урлахуй үйлд сайн. Их усыг гатлах, догшин газрыг номхотгох, загас барих, тангараг тавих, нүүдэл суудал хийх, цөөрөм, суваг татах, дайсныг дарах, дайсны газар одохуйд муу.

Гин-д бурхныг тахих, номын үүднээ орох, пүрвийн хариулгаар дарах, адуу, үхэр сургах, байшингийн суурь тавих, гэр бүрэхэд сайн. Ихэтгэх, ном унших, худалдаа, арилжаанд муу.

Син-д бурхныг тахих, чимэг зүүх, мод хатгах, байшингийн суурь тавихад сайн. Тээрэм босгох, тангаргалах, хурал цуглаан хийх зонхид муу.

Гуравдугаарт, Есөн мэнгэ өдөрт ургасны үр нь:

Нэг цагаанд угаал үйлдэх, бурхан, лусыг тахихад сайн. Нялхсыг хөлд оруулах, гадагш гаргахад муу.

Хоёр хард шимунас хийгээд эрлэгийг тахих, хараалыг дарах, буцаахад сайн. Гаслан гашуудах, шөнийн явдлыг үйлдэх, бурхныг тахих, бэрийн үйлд муу.

Гурван хөхд усан балин гаргах, лусын балин

гаргах, хүчир лус хийгээд эмт газрын эзнийг тахихад сайн. Газар малтах, ухах, ховхлох, мод таслах, цөөрөм, худаг малтах, бурхныг тахих, бэрийн үйлд муу.

Дөрвөн ногоонд эм найруулах, найман лусыг тахих, өглөг өгөх, бурхныг тахих, өглөгийг үйлдэх зэрэгт сайн. Бэлбэсний газар очих, үс авахуулах, угаал үйлдэх хийгээд нялхсыг гадагш гаргахад муу.

Таван шард хан адыг тахих, сүм дуганыг сэргээх, амьлуулах, тойн болох, ном номлоход сайн. Газар малтах, хурим найр хийх, нохой авахад муу.

Зургаан цагаанд бурхныг тахих, хишиг даллага дуудуулах, угаал үйлдэх, наманчлах, бэр авах, нүүдэл суудал хийхэд сайн. Гаслан гашуудах хийгээд буртаглах, бузарлах, өслөх үйлд муу.

Долоон улаанд гараг хийгээд албин, бод хийгээд бурхныг тахибал сайн. Цэрэг, дээрэм, хом шатаах, улай, хярвасны үйлд муу.

Найман цагаанд бурхныг тахих, угаал үйлдэх, сан тавиулах, хангал уншуулах, бэрийн үйл, өлзийг өгүүлэхүй, сахиусанд ачлахуй тахил өргөх, балин өргөхөд сайн. Хиншүү хярвас гаргах, бузарлах, бэлбэсний үйлд муу.

Есөн улаанд насан бүтээл хийгээд хишиг даллага дуудуулах, нааш авахуйд сайн. Гэрэлтэн [29]-ийг гадагш өгөх, гаргахад муу. Эмгэн өвгөн үхвэл хишгийн хүрээ эвдрэх муу.

Дөрөвдүгээрт, Шүтэн барилдлагыг тоолохуй ёс адил үгүй олон байдаг ч “Цагаан бэндэрьяа“ тэргүүтэнд хугас дундыг хөөн тоол тоолохыг номлосон буй. Тэр ч хугас дундаас хойт хугас дунд хүртэлхи хоног лугаа нийлүүлж шүтэн барилдлагыг тоолсон байдаг болой.

Тэр ёсыг хүснэгтэд байгуулбал:

Сарны Ордны Нэр	Нум	Матар	Хумх	Загас	Хонь	Үхэр
Мунхаг	1 16	12 17	11 18 28	10 19 29	9 20 30	8 21 32
Хуран үйлдэ-хүй	2 27	1 16	12 17	11 18 28	10 19 29	9 20 30
Тийн Мэдэхүй	3 13 26	2 27	1 16	12 17	11 18 28	11 18 28
Нэр өнгө	4 14 25	3 13 26	2 27	1 16	12 17	11 18 28
Төрөн түгэхүй	5 15 24	4 14 25	3 13 26	2 27	1 16	12 17
Хүрэлцэ-Хүй	6 23 31	5 15 24	4 14 25	3 13 26	2 27	1 16

Сарны Ордны Нэр	Хамтат-гах	Мэлхий	Арслан	Охин	Жин-лүүр	Хилэнц
Мунхаг	7 22	6 23 31	5 15 24	4 14 25	3 13 26	2 27
Хуран үйлдэ-хүй	8 21 32	7 22	6 23 31	5 15 24	4 14 25	3 13 26
Тийн Мэдэхүй	9 20 30	8 21 32	7 22	6 23 31	5 15 24	4 14 25
Нэр өнгө	10 19 29	9 20 30	8 21 32	7 22	6 23 31	5 15 24
Төрөн түгэхүй	11 18 28	10 19 29	9 20 30	8 21 32	7 22	6 23 31

Хүрэлцэ- хүй	12 17	11 18 28	10 19 29	9 20 30	8 21 32	7 22

Сарны ордны нэр	Нум	Матар	Хумх	Загас	Хонь	Үхэр
Сэрэхүй	7 22	6 23 31	5 15 24	4 14 25	3 13 26	2 17
Хурь-цахуй	8 21 32	7 22	6 23 31	5 15 24	4 14 25	3 13 26
Авахуй	9 20 30	8 21 32	7 22	6 23 31	5 15 24	4 14 25
Сансар	10 19 29	9 20 30	8 21 32	7 22	6 23 31	5 15 24
Төрөхүй	11 18 28	10 19 29	9 20 30	8 21 32	7 22	6 23 31
Өтлөхүй үхэхүй	12 17	11 18 28	10 19 29	9 20 30	8 21 32	7 22

Сарны ордны нэр	Хамтат- гах	Мэлхий	Арслан	Охин	Чинлүүр	Хилинц
Сэрэхүй	1 16	12 17	11 18 28	10 19 29	9 20 30	8 21 32
Хурь-цахуй	2 27	1 16	12 17	11 18 28	10 19 29	9 20 30
Авахуй	3 13 26	2 27	1 16	12 17	11 18 28	10 19 29
Сансар	4 14 25	3 13 26	2 27	1 16	12 17	11 18 28

Төрөхүй	5 15 24	4 14 25	3 13 26	2 27	1 16	12 17
Өтлөхүй үхэхүй	6 23 31	5 15 24	4 14 25	3 13 26	2 27	1 16

Шүтэн барилдлагын үрийн номлол нь: Энэ мэт.

Мунхаг шүтэн барилдлагатай өдөр сүм, дуган, суврага босгох хийгээд үхэгсэдийн газар олох тэргүүтэн хурал цуглаанд сайн. Үүнээ төрсөн хөвгүүн, охин есөн хоног, есөн сар, есөн жил дээрээ эс үхвээс хязгаар орны эрхэм болон баялаг, хувь сайт болно. Хурьцахуй сэтгэл ихт, сэтгэл нь ширүүн, зөөлөн өгүүлэгч. Наян нэг наслаюу [30]. Хуран үйлдэхүй өдөр үхнэ хэмээн номложээ. Өвдвөл машид сэрэмжилж үйлд. Арван таван хоногт эс үхвээс тэндээс тав дахь өдөртөө эдгэрнэ. Үүнээ замд гарвал хэрэг бүхэн бүтнэ. Үүнд эд алдваас хулгайч нь умар зүгээс ирсэн муухай үст нэгэн аваачсан. Гэрийн зүүнтээ хол үгүй буй. Есөн хоногоос олдюу. Нүд татвал эцэг, эхэд аймшиг болно. Баруун чих хангинавал бүсгүй лүгээ учирна. Зүүн болвоос идээ, ундаа олдох болой. Нохой ульвал гэнэтийн зочин ирнэ. Энэ өдөр хэрээ дуугарвал өндөр дээд язгуурт хүмүүний яриа захиа ирнэ. Тагнай эрвэгнэвэл их хүмүүн ирэх болой. Биеийн мах таталзвал хэрүүл, тэмцэл, уй гашуу болмуй. Шилбэний мах таталзвал буянтай гэж номложээ.

Хураан үйлдэхүй шүтэн барилдлагатай өдөр өдөр үсэг, зурагт суралцах хийгээд бэрийн үйл, буяны үйл, дайсныг номхотгоход сайн. Түүнд төрвөөс хоног, сар, жил наймд эс үхвээс үнэн өгүүлэгч, ёсыг мэдэгч, мэргэн ба ариун явдалт, амьтнаа туслан үйлдэгч, наян

найм хүрч наслана. Тийн мэдэхүй өдөр өөрийн нутагтаа үхнэ. Замд гарвал эдээгээр ханах ба хөвгүүн эд олон хөвгүүн баясан хуримлаюу. Шар царайтай, дээрэм хулгайд баясагч муу хувцас өмссөн тэр хулгайч дорноо аваачсан бөгөөд яргачинд өгчээ. Зүүн нүд татвал үзэсгэлэн болох бөгөөд баруун нүд татваас үйл өчүүхэн бүтюү. Баруун чих хангинавал үзэсгэлэнтэй болно. Зүүн чих хангинавал буянтай болно. Нохой ульвал хааны үйлийг үйлдэх хэрэг гарна. Хэрээ дуугарвал өөрийн цусыг үзюү. Тагнай эрвэгнэвэл гэрт үзэсгэлэн болоод бүх биеийн мах таталзвал эдийг олох болой. Шилбэний мах татганавал буянтай болно.

Тийн мэдэхүй шүтэн барилдлагатай өдөр өдөр эм засал хийх, абшиг эрх өгөх, бэрийн үйл хийгээд дайсныг номхотгох, хурал цуглаан хийх, үс авахуулах, угаал үйлдэхэд сайн. Түүнд төрсөн хүмүүн есөн хоног ба найман сар, найман жил эс үхвээс нисваанис [31]-ыг үйлдэгч лам, баатарлаг, хүч зоригтой, дайсныг дарагч, үргэлжид ширүүн үгийг хэлэгч, хилэнцэд баясагч, дээд суудалтны ачаар амьдрагч, жаран дөрөв хүрч наслана. Нэр дүрс өдөр мэсээр үхнэ. Өвдвөөс гурав буюу таван хоног, найман хоногт үхэхгүй бол түүний хойно долоо дахь хоногоос эдгэнэ. Замд гарвал эдийг олох ба тахилыг олюу. Хулгайч нь гэрт суугч, шар цайвар харайтай, охор хоншоорт нэгэн аваачжээ. Сураг сонсохгүй ч олох болно. Зүүн нүд татвал хувцас олюу. Баруун татвал хэрүүл, тэмцэл ирьюү. Баруун чих хангинавал хүндлэлийг олно. Зүүн чих хангинавал өмнө үзээд, үзэгдэхээ больсон нэгнийг өчүүхэн төдий үзэх болно. Нохой улих ба хэрээн дууны үрийг номлоогүй. Тагнай эрвэгнэвэл үзэсгэлэн болох мөн. Бүх биеийн мах татвалзвал аюул

болюу. Шилбэний мах татвал сураг ажиг ирюү.

Нэр өнгө шүтэн барилдлагатай өдөр аюулаас зугатах ба лам лугаа учрах ба цагаан зүгийн үйлд сайн. Түүнд төрсөн хүмүүн зургаа, есөн сард амьдарваас оюун ухаан муутай, билиг нь өчүүхэн, илч муутай, урин ихтэй. Хөвгүүд хийгээд доодост асрахуй, омог ихтэй, баатар заль ихт, наян нэг хүрч наслана. Төрөн түгэхүй өдөр үхюү. Өвдвөл гурав, таван хоногт амирлах, үхэх нь ялгарна. Замд гарвал муу. Гаслан лугаа учиран, амраг саднаас хагацюу. Хулгайч нь хоёр хүмүүн бөгөөд нэг нь цагаан үстэй, царай муутай, урлахуй ухааныг мэдэгч тэд аваачсан, хорин нэг хоногоос олдюу. Нүд татвал баруун бол холын сураг дуулдна, зүүн болвоос эдийг олюу. Баруун чих хангинавал ундаа олно. Зүүн хангинавал хүлэгдэх болой. Нохой ульвал үхсэний хэл дуулна. Хэрээ дуугарвал нөхөртэйгээ учирна. Тагнай эрвэгнэвэл олз олюу. Биеийн мах татвалзвал эцэг, эхэд гэм ирнэ. Шилбэний мах татвал хэрүүл, тэмцэл гарахын ёр буй.

Төрөн түгэхүй шүтэн барилдлагатай өдөр хувцас урлах, орныг барих, санд нуух зэрэгт сайн. Түүнээ төрсөн хүмүүн хоёр буюу дөрвөн сар буюу найм, есөн жилд үл үхвээс ахуй ёс нь муу, эцэг, эх нь үгүйрюү. Ариун явдалт ба хармын сэтгэлт, жаран дөрөв хүрч наслана. Хүрэлцэхүй өдөрт үхнэ. Өвдвөл долоо хоногоос амирлана. Замд гарвал бэлэг, өлз олно. Асрахуйн үгийг олюу. Том нүдтэй, шар царайтай, хэвлий ихтэй хулгайч авч, усны хөвөө шүтсэн айлын нэгэн өвчтэй хүмүүнд өгөөд оджээ. Нэг хоногт эс олвоос хожим олдох нь бэрх. Зүүн нүд татвал эцэг, эх, амрагийн хэрэг бүтнэ. Баруун татвал эд барагдана. Баруун чих хангинавал өчүүхэн

төдий аймшиг болно. Зүүн чих хангинавал хэрүүл, тэмцэл болно. Нохой ульвал чалчаа (шалдар булдар) яриа гарюу. Хэрээ дуугарвал жуулчин ирнэ. Тагнай эрвэгнэвэл сэтгэл үймэрнэ. Биеийн мах татвалзвал хэрэгтэй үйл бүтнэ. Шилбэний мах татвал үзэсгэлэн болно.

25.12.2998

Хүрэлцэхүй шүтэн барилдлагатай өдөр хараал, хатуу үйл хийгээд өглөгийн түллэг тэргүүтэн үйлд сайн. Түүнд төрсөн хүмүүн гурван сар хийгээд есөн жилд үл үхвээс судар шашдир, элдэв урлахуй ухааныг мэдэгч, арга зальтан, эд баялаг өчүүхэн ба атаа ихтэй, жаран гурав хүрч наслана. Мэдрэхүй өдөр усанд үхьюү. Өвдвөл гурван хоногт үхнэ, эсбөгөөс өнөд өвчнөөр энэлюү. Замд гарвал өнө холдоо дээрэмтэй тааралдана. Хулгайч нь өөрийн шадар агч үргэлжид ирдэг ба яриа ихтэй, хар үстэй арилжааг арвитгагч тэр дөрвөн хүмүүнтэй нөхөрлөж хулгайлан аваад хол гаргасан байна. Бусадтай маргалдаж, цуур тарж олдоно. Зүүн нүд татвал үр үгүй ба баруун нүд татвал эдийг олно. Баруун чих хангинавал аймшиг болно. Зүүн чих хангинавал жуулчид ирнэ. Нохой ульвал хулгайч ирнэ. Хэрээ дуугарвал айх, цочих болно. Тагнай эрвэгнэвэл амгалан болох ба биеийн мах татвалзвал эцэг, эхэд айх цочих болно. Шилбэний мах татвал хэрүүл, тэмцэл болно.

Сэрэхүй шүтэн барилдлагатай өдөр амраг лугаа учрах ба абшиг айлтгах, ус гатлах, угаал үйлдэх тэргүүтэнд сайн. Түүнд төрсөн хүмүүн хоёр ба далан хоног, найман сард үл үхвээс хилинцэт, оюун төгс, чалчаа үгтэй, эд баялаг өчүүхэн, урлахуй ухаан хийгээд огоорохын арганд мэргэн, гучин зургаа ба тавин тав

хүрч наслана. Хурьцахуй өдөр үхнэ. Өвдвөл арван хоногоос амирлана. Замд гарвал идээ, ундаа, хувцас чимэг олно. Үзэсгэлэнт эм лүгээ учирна. Алдсанаа олно. Холоос ирсэн, алаг нохой дагуулсан нэгэн хулгайч авч оджээ. Нэг хоногт олдох нигууртай. Баруун нүд татвал амраг садан ирнэ. Зүүн нүд татвал хүндлэлийг олно. Баруун чих хангинавал гаслан болно. Зүүн чих хангинавал алдаж, завхарсныг сонсох болно. Нохой ульвал тэмцэл болно. Хэрээ дуугарвал жуулчин ирнэ. Тагнай эрвэгнэвэл айх цочих болно. Бүх биеийн мах татвалзвал өмнөөс жуулчин ирнэ. Шилбэ татвал хэрүүл, тэмцэл, гэмшихүй дуун болно.

Хурьцахуй шүтэн барилдлагатай өдөр буяны үйл, шинэ хувцас өмсөхүйд сайн. Түүнд төрсөн хүмүүн нь арван хоног, гурав, таван сар, есөн жилд үл үхвээс шагшабад лугаа төгөлдөр, амирлангуй, тэр бээр эд, буян нь хотол чуулган лугаа бүрдсэн, урлахуйд мэргэн ба дайсан бүхнийг номхотгогч, тавин тав буюу жаран дөрөв хүрч наслана. Авахуй өдөр насны хэмжээ төгсөнө. Өвдвөл найман хоног ба хорин нэгэн хоногт эдгэх, үхэх нь ялгарна. Замд гарвал сэтгэл хямрах болно. Хулгайч нь өрнөөс ирсэн нэгэн гуйлгачин мөн. Тэр хулгайлж, хар нохойтын нэгэн хүмүүнээ өгсөн буй. Хэрэлдэж эзэнд нь тушаах болюу. Зүүн нүд татвал олз олно. Баруун нүд татвал юу ч үл өөрчлөгдөх болно. Баруун чих хангинавал үзэсгэлэн болно. Зүүн чих хангинавал үхсэний сураг дуулна. Нохой ульвал сонсголонтой сураг дуулна. Хэрээ дуугарсны үрийг номлоогүй. Тагнай эрвэгнэвэл гэрийн үйлс арвижюу. Биеийн мах татвалзвал хар, шар хоёр ирэх болой. Шилбэний мах татвал хэрүүл тэмцэл гарах ба гашуудлын дуун гарюу.

Выжить после 64-х : до 93!

Авахуй шүтэн барилдлагатай өдөр эм найруулах, эхнэрийг дуудах, үс хяргах, элч илгээх, эд авахуйд сайн. Түүнд төрсөн хүмүүн хоёр хоног, есөн сард үл үхвээс омогтой, баялаг, олныг өгүүлэгч, санаа муут нэгэн болно. Жаран дөрөв ба ная хүрч наслана. Сансар өдөр өөрийн орон нутагтаа үхмүй. Өвдвөл найм дахь хоногд үл үхвээс арван хоногоос амирлана. Замд гарвал сайн ба эд, идээ олдоно. Хулгайч нь дорноос ирсэн хоёр хүмүүн бөгөөд хулгайлаад, өрнө оджээ. Тэр эдээсээ болж хэрүүл тэмцэл болцгоож, эзэнд нь өгнө. Зүүн нүд татвал хэрүүл, тэмцэл болно. Баруун татвал эд, хувцас олдно. Зүүн чих хангинавал жуулчин ирнэ. Баруун чих хангинавал гаслан болно. Нохой ульвал халуун болно. Хэрээ дуугарвал амраг садан үхмүй. Тагнай эрвэгнэвэл хэн нэгэн үхмүй. Биеийн мах татвал гэнэтийн жуулчин ирнэ. Шилбэний мах татвал үхлийг үзүүлж буй хэрэг.

Сансар шүтэн барилдлагатай өдөр бурхны егүзэр хийгээд тарни бүтээгч, янагийг хураваас сайн. Түүнд төрсөн хүмүүн есөн хоног, хоёр сар буюу есөн жилд үл үхвээс баатарлаг, ид хүч ихтэй, эцэгтээ уринлагч. Хорт үйлд хичээгч, өвөрчилөн муу, жар буюу хорь наслана. Төрөхүй өдөрт үхлийн эзэн аваачна. Өвдвөл гурав буюу таван хоногт үл үхвээс найм дахиас зонхи нь амирлана. Замд гарвал гаслан, хагацал болно. Хааны цаазын аюул болно. Хулгайч нь дорноос ирсэн хөнгөн дээрэнгүй, машид хэсэгч, тэр хүмүүн хулгайлан, хол гаргаж, нэгэн хүмүүнийг хуурч орхижээ. Олдохын нигуур буй. Зүүн нүд татвал өрнийн жуулчин ирнэ. Баруун татвал алдсаныг олюу. Баруун чих хангинавал асрахуй хийгээд үзэсгэлэн болно. Зүүн чих хангинавал буянтай болно гэж номлосон буй. Нохой ульвал гэрийн тэнгэр

зайлмуй. Хэрээ дуугарвал эд, эдлэл олдно. Тагнай эрвэгнэвэл жуулчин ирнэ. Бүх бие татвалзвал гаслан төрмүй. Шилбэний мах татвал хувцас олдно.

Төрөхүй шүтэн барилдлагатай өдөр гэрийн үйл хийгээд бие угаах, хувцас өмсөх тэргүүтэнд сайн. Түүнд төрсөн хүмүүн таван хоног, есөн сар, арван жилд үл үхвээс ядуу ба номын явдалт, үнэн өгүүлэгч, амрагтаа асрахуй, урлахуйд мэргэн, өвөрчилөн сайн болно. Зуу хүрч наслах ба өтлөх үхэхүй өдөрт үхмүй. Өвдвөл найм буюу арван хоногт хүчир. Тэгээд түргэн эдгэрюү. Замд гарвал эд олдож, хэрэг бүхэн бүтнэ. Хулгайч нь дотрын нэг хүмүүн, гадны хоёр хүмүүн лүгээ гурвуул аваачжээ. Өнө болсны дараа олдох болой. Зүүн нүд татвал хувцас олдоно, баруун татвал жуулчин ирнэ. Баруун чих хангинавал баясгалан болох ба зүүн чих хангинавал муу. Нохой ульвал амгалан болох ба хэрээ дуугарвал сайн, муугийн ялгаа үгүй. Тагнай эрвэгнэвэл дээрэмчин ирнэ. Бүх бие татвалзвал аюул болох бөгөөд шилбэ татвал өвдөх болой.

Өтлөхүй, үхэхүй шүтэн барилдлагатай өдөр эдийг хураах, номын өглөг өгөх хийгээд угаал үйлдэх, эдийг гадагш өгөх тэргүүтэнд сайн. Түүнд төрсөн хүмүүн сар, жил есд үл үхвээс сэтгэл нь өчүүхэн, их идэгч, омогтон, өвчин хуучтан, хилэнцэт явдалтай, ширүүн өгүүлэгч, ахуй ёсон муу нэгэн болно. Жаран дөрөв наслаж, мунхаг өдөрт насан төгсюү. Өвдвөл гурван хоног ба долоон хоногт үл үхвээс өвчин амирлана. Замд гарвал ажил хэрэг нь шим үгүй болно. Умраас ирсэн өндөр, сөөнгө, хугархай шүдтэй, цагаан үстэй ба уруул нь унжуу нэгэн хулгайч аваачжээ. Хорин тав хоногийн дотор олдоно. Зүүн нүд татвал хувцас олюу. Баруун нүд

татвал элч лүгээ учирна. Чих хангинавал сайн, муугийн ялгал үгүй. Нохой улих ба хэрээ дуугарахын үрийг номлоогүй. Тагнай эрвэгнэвэл өөрийн гэрт үзэсгэлэн болно. Биеийн мах татвалзвал бурхан дагуулан соёрхох болой. Шилбэний мах татвал гаслан болно. Тэр мэт тэргүүтэн олныг номлодог боловч товчлон хурааж, үгийг цөөлөхийн ёсоор байгуулав.

Шүтэн барилдлагыг цаг лугаа тохируулан барилдуулах нь: Мунхаг шөнө дунд, Хураан үйлдэхүй шөнө дунд хэвийхэд, Тийн мэдэхүй нь торон баранд, Нэр өнгө үүрээр, Төрөн түгэхүй нь нар ургахуйд, Хүрэлцэхүй нь нар хөөрөхөд (Бүлээдэхэд). Мэдрэхүй нь бага үдэд, Хүрьцахүй нь үд хэвийхэд, Авахүй нь нар гудайхад, Сансар нь нар шингэхэд, Өтлөх үхэхүй нь газар борлоход, Төрөхүй нь харанхуй бүрэнхийд, тэр мэт ёсоор гармуй, буцах ёсон гэдрэг мэт. хэмээсэн болой. Бас бус хоногт ургахын ёсыг ухахыг номлосон хүрд ч байдаг билээ.

Зарим нэгэн " Тантрын тайлбар"-т үүсгэн, хураахын бодат нигуурын ургах ёсыг зарлигласан тул эндүүрч, шинийн хоногт байгуулсан ба орд лугаа найруулаад зарлигласан болохоор эндүүрч, ордны хоногт байгуулах тэргүүтэн нь "Тантрын тайлбар" ямагтаас нарны арван зургаан хоногийн шүтэн барилдлагыг зарлиглах тэргүүтнээр хаахын тулд огоорч үйлдэх хэрэгтэй. Алинаа ургахын үндэс нь өөрийн гараг лугаа нийлүүлсэнээр ч нарны хоногт ургах нь үндэсний таалалд бүтсэн болой.

Сүлд тэргүүтэн гараг, одны үр

Сүлд тэргүүтэн гараг, од нь:

Арван хоёр жил	Хулгана	Үхэр	Бар	Туулай	Луу	Могой
Сүлд гараг	4	0	5	5	1	3
Амин гараг	3	4	0	0	4	6
Дайсан гараг	0	5	6	6	5	4
Сүлд од	19	16	4	10	2	12
Амин од	5	13	26	26	23	11
Эрхтэн од	2	11	8	11	16	5
Харш од	25	1	13	25	7	7
Шимунас од	9	7	11	14	8	8
Дайсан од	22	4	1	17	10	5
Ивээл гурав	луу бич	могой тахиа	морь нохой	гахай хонь	бич хулгана	тахиа үхэр
Дайсан яргач	морь	хонь	бич	тахиа	нохой	гахай
Дөрвөн яргач	туулай тахиа	луу нохой	могой гахай	морь хулгана	үхэр хонь	бар бич
Жил од	туулай	бар	үхэр	хулгана	могой	луу
Арван хоёр жил	Морь	хонь	Бич	Тахиа	Нохой	Гахай
Сүлд гараг	3	6	6	6	2	4
Амин гараг	6	2	5	5	4	3
Дайсан гараг	4	5	3	3	5	0
Сүлд од	16	7	7	13	8	1
Амин од	11	0	0	6	26	7
Эрхтэн од	5	1	1	24	4	10
Харш од	19	19	8	2	10	25
Шимунас од	4	4	4	10	2	2
Дайсан од	26	26	26	23	11	11
Ивээл гурав	бар нохой	гахай туулай	хулгана луу	могой үхэр	бар морь	туулай хонь

Дайсан яргач	хулгана	үхэр	бар	туулай	луу	могой
Дөрвөн яргач	туулай тахиа	луу нохой	могой гахай	морь хулгана	хонь үхэр	бич бар
Жил од	тахиа	бич	хонь	морь	гахай	нохой

Ялангуяа өөрийн дээр [32], өнцөг долоо [33] хийгээд ивээл гурав [34], дөрвөн яргач [35], жил одыг тэвч. Жил, сар, хоног, цагийг ч энэ мэт найруулан мэд.

Сүлд гарагт аливаа үйлс бүтмүй. **Амин гарагт** буянтай, дайсан гарагт буян зайлмуй. Тийм боловч дайсны сүлд гараг доройтно. Дайсан гараг дэлгэрэх цагт хараал хүчтэй болно. Эх, нөхөр гарагт аливаа хэрэгт сайн. Хөвгүүн гарагт дунд зэрэг. **Амь, сүлд, эрхтэн одод** аливаа хэрэг сайн. Эх, нөхөр одонд буянтай болно. Хөвгүүн дунд, харш, шимунас, дайсан гуравт муу. Тийм боловч дайснаа тотгорыг номхотгоход сайн. Эхээс төрөх үедээ сүлд одтойгоо тохиовол насан урт болно. Эрхтэн од лугаа тохиовоос буян ихтэй. Дайсан од лугаа тохиовоос насан охор болно. Ялангуяа чухалчилваас бодагал бүхэнд гараг, од адил үгүйг зарлигласан бөлгөө. Төрсөн гараг, өөрийн гараг, сүлд гарагт хатуу, зөөлөн, нийтийн, ялангуяа цэрэглэх, хүч гаргах, наманчлах, худалдаа арилжаа хийх, хүчийг үүсгэх, мөрийтэй тоглох, морь уралдуулах, доройтуулах, хямруулах үйлд сайн. Эх, нөхөр гарагт ч зүгтэйгээ тохирон буянтай. Махбодын дайсан гарагт үйл бүхнийг тэвчээрэй. Төрсөн од ургахын цагт хатуу, зөөлөн нийт үйл, ялангуяа бурхныг тахих, ламд өргөл хүндлэл үйлдэх, өглөг өгөх, буяны үйл, чимэг хувцас өмсөх, зүүх, шинэ гэр барих, мод суулгах, байшингийн үйлд өлзийтэй.

Сүлдний орон тэргүүтний үр

Сүлдний орон тэргүүтэн чухал хэрэгтэй бүхнийг нэгэн зүгт жигдлээд өгүүлэе. Сүлдний орныг тоолох ёс. "Тантрын тайлбар"-аас зарлигласан ёс нь: Хурууны үес тэргүүтнээ оршихуй гучин хоёрд махбода үсгийн байдлаар оршиж, өдрийн эрхээр юүлэн нүүнэ. Тэр ч сар шинэдийн эрхээр үйлдвээс ро, жан (རོ། རྐྱང་།) судлын ахуй ёсны эрхээр эрийн зүүн, эмийн баруун зүгээс эхийг зохиогоод, шинийн нэгнээ хөлийн хурууны анхдугаар үед (ཨཿ) үсэг, хоёронд (ཨི།), гурванд (རི།), дөрвөнд олгойд (ཨུ།), тавнд өвдгөнд (ལྀ།ཧཱུྃ, зургаанд сүүжний уулзварт (ཨ།), долоонд гарын хурууны анхдугаар үед (ཨི།), наймнд хоёрдугаар үед (ཨར།), есөнд гуравдугаар үед (ཨོཾ།), арванд эгэмний уулзварт (ཨཡ།), арван нэгэнд мухар тохойд (ཀ།), арван хоёронд мөрнөө (ཡ།), арван гурванд хоолойд (ར།), арван дөрвөнд зулайд (ཝ།), арван тавнд манлайд (ལ།), арван тав, арван зургаагийн завсарт (ཨཾ།), бас дахин арван зургаанд духанд (ཡཱ།), арван долоонд хүзүүнд (ཝཱ།), арван наймнд зүрхэнд (རཱ།), арван есөнд мөрний үед (ཡཱ།), хоринд мухар тохойд хаа (ཀཱ།), хорин нэгэнд эгэмд (ཨཱཡ།), хорин хоёронд гарын хурууны гуравдугаар үед (ཨཱོཾ།), хорин гурванд хоёрдугаар үед (ཨཱར།), хорин дөрвөнд анханд (ཨཻ།), хорин тавнд сүүжний ясны завсард (ཨཱ།), хорин зургаанд хуруунд (ལཱི།), хорин долоонд олгойд (ཨུ།), хорин наймнд хөлийн хурууны гуравдугаар үед (ཧཱུ།), хорин есөнд хоёрдугаар үед (ཨཱི།), битүүнд анхдугаарт (ཨཱ།), битүүний цээж ба шинийн нэгний завсарт хөлийн улнаа (ཨཱཿ)-гийн дүрст бөлгөө. Энэ хийгээд дээд тэргүүнээ (ཨཾ)-ын үест бүх биенээ түгэхүй тул машид хүчир гэж зарлигласан бөлгөө. Бас бус "Хэрүга галбо (ཧེ་རུ་ཀ་གལ་པོ།)"-гын дөрөвдүгээр шинжлэлд эрхий хуруу анхны өдөр хагас үгүй (ཨ།) үсэг

хэмээх тэргүүтэн арван зургаан эгшиг лүгээ найруулж зарлигласан буй.

Түүнчлэн “Санваар гарсан (སྡོམ་འབྱུང་།)”, Дагинисын далай (མཁའ་འགྲོ་རྒྱ་མཚོ།)”-гаас ч номлосон бөлгөө. “Нарны гэрэл (ཉིན་བྱེད་སྣང་བ།)”-д байгуулсан сүлдний орон нь түүний тайлбарт : “Эрдэнийн эрих (རིན་ཆེན་ཕྲེང་།)”-ийн ёс хэмээн гарсан алинаа шүтэхийг мэдэхгүй” хэмээн зарлигласан ч “Цагаан бэндэръяа (བཻ་དཀར།)”-гаас: “Тэжээхүй ухаан лугаа ч тохирно, Пүгва Хүвон (ཕུག་པ་ལྷ་དབོན།)-гийн тааллын ёс “Эрдэнийн эрих (རིན་ཆེན་ཕྲེང་།)” мэт өгүүлбэл” хэмээн зарлигласнаар шинжилж үйлдэх болой. Аль мэт ч хоёр гол судрын нэгэн “Эрдэнийн эрих“-ийн хүмүүн малын сүлд оршихуйг өдөр лүгээ дүйлгэн хүснэгтэд байгуулсан нь:

1	2	3	4	5	6
хөлийн эрхий	хөлийн өлмий	хонгоны булчин	бэлхүүс	тахимны хонхор	гуяны зураа
ул	өөх	хянгар шилби	борви	тойгны яс	сүүжний нүх
7	8	9	10	11	12
Сүүжний нүх	бөөрний дээр	хавирга	мөрөн дээр	гарын ар	гарын алга
тохойн үзүүр	бөөрний хонхор	гарын алга	дух	өөх	гарын ар
13	14	15	16	17	18
хоолй	чих зулайн хооронд	бүх биед түгэх	цохонд	хүзүү	гарын алга
цагаан судал	мөр	бүх бие	хүзүүн	хүзүү	сэрвээ
19	20	21	22	23	24
гарын ар	мөр	хавирга	бөөр	сүүжний нүх	гуяны зураа
дух	мөр	шүд	тагнай	хэл	магнай
25	26	27	28	29	30

тахимны хонхор	мөр	хонгоны булчин	олгой	хянгар шилбэ	бүх бие
өвчүү	мөгөөрсөн хоолой	нууц	товч	хамрын нүх	биед тарна

Үүний дээр нь хүмүүний, доор нь малын сүлдний орон байгаа болой.

Бас "Санваар гарсан"-ы сүлдний орныг хүснэгтээр байгуулбал:

1 16	2 17	3 18	4 19	5 20	6 21	7 22	8 23
хөлийн ул	өлмий	гуяны дотор	нууц	хүйс	зүрх	хөх	багал-зуур

9 24	10 25	11 26	12 27	13 28	14 29	15 30
гар	ам	хацар	нүд	чих	толгой	бүх биед түгнэ

Мэргэдийн эрхт Дарма маарамба [36]-ын зохиосон "Эмийн гол нууц тэмдэгт увдис" номоос гарсан өдрийн сүлд орших орон нь:
О нахождении духа по органам и частям

1	2	3	4	5	6	7	8	9	10
хөлийн эр хий	олгой	хонго	гуян дотор	тахимны хонхор	гуяны зураа	өвчүү	зүрх	хүзүү	багал-зуур

11	12	13	14	15	16	17	18	19	20
хамрын үзүүр	магнай	цох	хамрын үзүүр	бүх биед	дух	дал	хонго	хүзүү	тахимны хон-хор

21	22	23	24	25	26	27	28	29	30
хавирга	суга	гар	бөөр	сүүжний нүх	хар мэлхий	нууц	хянгар шил-бэ	ар	бүх биед

Ом загчу дэ ва хри магий сууха

Бас бус өмнөх сан хэмээх сангийн гэрт хөлийн улд орших мэт тэргүүтэн “Нууц тэмдэгт увдис“-аас гарсан цагийн сүлд орших нь: Посвящение о тайных знаках

үүр цайх	нар ургах	нар хөөрөх	үд дунд	үд хэвийх	нар гудайх
хоншоор	ам	хэл	нүд	нарийн гүрээ	улаан хоолой

нар шингэх	үдэш	бүрэг тараг	шөнө дунд	шөнө хэвийх	торон баран
цорой	хэвлий	нууц	ходоод	өвчүү	гэдэс

Энэ мэт тэргүүтэн сүлдний орныг тоолох ёсон адил үгүй олон буй. Ямар мэт хэмээвээс “Цагаан бэндэрьяа”-гаас “Түүнд сүлдийн орныг гадсаар дэлдэх тэргүүтэн илт үйлийг мэдэн анхаар. Хүмүүн, малын сүлд буй орноо ханур, төөнүүр тэргүүтэн хөндөх заслыг тэвч” хэмээн номлосон бөлгөө. “Нууц тэмдэгт увдис (མན་ངག་བཀའ་རྒྱ་མ)”-аас: “Ханур, төөнүүр хийхгүй байх аргагүй болвоос **Ум загчү дэ ва хри ма ги суухаа** (ཨོཾ་ཙཀྲ་དེ་བ་ཧྲི་མ་གི་སྭཱ་ཧཱ) тарнийг урьж ханур, төөнүүр хийвээс гэм бүгд арилна” гэжээ.

Ханур, төөнүүр хийх үед жилтний тухайд зарим сар ханур, төөнүүр хийж болохгүй байдаг. Хулгана жилтнийг өвлийн дунд сард төөнөж үл болно. Үхэр жилтнийг зуны тэргүүн сард төөнөж болохгүй. Бар жилтнийг зуны адаг сард төөнөж болохгүй. Туулай жилтнийг намрын тэргүүн, зуны адаг сард төөнөж болохгүй. Луу жилтнийг өвлийн адаг сард төөнөж болохгүй. Луу, могой, морь, хонь дөрвийг нар жаргахаас хойно, шөнө төөнөж болохгүй. Бич, тахиа хоёрыг нар ургахуйд төөнөж болохгүй. Нохой, гахай хоёрыг нар

хөөрөхүйд төөнөж болохгүй болохоор мэргэд нягтлан бод“ гэж зарлигласан бөлгөө.

Эмийн гол судар тэргүүтнээс эрхэмлэн барьж анхаарсан **хутга өдөр** хэмээхүй өдөр нь хаврын гурван сарын хулгана, гахай өдөр. Зуны гурван сарын бар, туулай; Намрын гурван сарын морь, могой өдөр; Өвлийн гурван сарын бич, тахиа өдөр болно. Тэр цагт ханиур хийх, мал засахыг тэвч.

Газрын сүлд оршихыг тоолох нь: “Үхэр, хонь хийгээд нохой, луу дөрвөн өдөр газарт газрын сүлд оршино” хэмээн номлосон буй. Энэ өдөр газар малтах, чулуу ховхлох, мод таслах хийгээд шинэ гэр барих ба шинэ газар буух, бэр авахуй, хүүр тавих тэргүүтнийг тэвч.

Арван хоёр жил	бар	туулай	луу	могой	морь	хонь
Саран магадлалгүй	морь	хонь	морь	могой	бар	нохой
Өдрийн тоо	9	6	7 10	11	12	11
Ханиур, төөнүүр тэргүүтнийг тэвчиж үйлд	нэг жилд үхэх болно	гурван сард үхэх болно	нэг жилд үхэх болно	нэг жилд үхэх болно	гурван жилд үхэх болно	гурван жилд үхэх болно
Арван хоёр жил	бич	тахиа	нохой	гахай	хулгана	үхэр
Саран магадлалгүй	морь	морь	могой	могой	луу	могой
Өдрийн тоо	11	11	11	11	8	11

Ханууp, т ө ө н ү ү р тэргүүтнийг тэвчиж үйлд	гурван сард үхэх болно	муу тул тэвч	муу Тул Тэвч	үхэх болно	нэг жилд үхэх болно	хоёр жилд үхэх болно

Цагийн барилдлагын хагасын эзэн гарагийг тоолох ёс нь: Өдөр, шөнийн хэмжээнээс арван хоёрт хуваасан ноогдвор нь хагасын хэмжээ. Хагас бүрд ээлжийн гарагаас эхлээд өдрийг зургаа эргэнэ, шөнийг таваар эргэх ёсоор ургах мөн болой. Шинжих арга нь алин бодох цагаас инагш нөгчигсөн хагасыг бодатой барих болой. Чуулган түүнийг өдөрт таваар, шөнөд дөрвөөр үржиж олсоныг бодох өдрийн ээлжийн гарагт нэмж, долоод огоорсны(ноогдворыг орхино гэсэн үг, орч) үлдэгдэл нь алин гарахуй хагасын эзэн гараг болно. Ерд зөөлөн гараг бол буянтай. Хатуу гараг бол буян бус болой. Ялангуяа Бархасвадь ургахын үест шимунасын цагийн завсар ургах болно. Үр нь хатуугаас бусдад үйл бүхэн бүтэх буянтай болой. Хагасын эзэн Санчир ургах үест бусад Төгс язгуурт [37]-ын цаг ургах болой. Тэр ч Санчирын эхэн, дунд, адгийн чинлүүр ургах хэмжээ нь ээлжийн гарагийг үзүүлнэ. Ээлжийн гараг Адъяа, Сумъяа, Бархасвадь гуравд голоос Адъяад арван зургаан чинлүүр, Сумъяад найман чинлүүр, Бархасвадьд гучин зургаан чинлүүр, ээлжийн гараг Ангараг, Будын эхнээс эхлээд чинлүүрийн хэмжээ Ангарагт зургаа, Будад хоёр, ээлжийн гараг Сугар, Санчирын цагт эцсийн дөрвөн чинлүүрт Ригдэн Догшин хүрдэт ургах болой. Наран ургах луу цагт хишиг даллага дуудуул хэмээх тэргүүтэн өмнө дурдсан эшд шүтэж, өдөр, шөнийн урт, охор алин мөн боловч үүр цүүр туулай хийгээд наран ургахуй луу

тэргүүтэн дараалан найруулахуй ч харагддаг.

Төгс язгууртан оршихуй эдэлбэр чинлүүрийн хэмжээ Бархасвадьд 33 чинлүүр болмуй.

Адъяа	голд	16
Сумъяа	голд	8
Ангараг	эхэнд	6
Буд	эхэнд	2
Бархасвадь	гол	36
Сугар	эцэст	2
Санчир	эцэст	4

Гараг	Үүр цайх		Нар ургах		Нар хөөрөхүй		Үд дунд		Үд хэвийх		Нар гудайх	
цагийн	эх	адаг	эх	адаг	эх	адаг	эх	адаг	эх	адаг	эх	адаг
Ад	1	6	4	2	0	5	3	1	6	4	2	0
Сум	2	0	5	3	1	6	4	2	0	5	3	1
Ан	2	1	6	4	2	0	5	3	1	6	4	2
Бу	4	2	0	5	3	1	6	4	2	0	5	3
Ба	5	3	1	6	4	2	0	5	3	1	6	4
Суг	6	4	2	0	5	3	1	6	4	2	0	5
Са	0	5	3	1	6	4	2	0	5	3	1	6

Гараг	Нар жаргах		Харуй бүрийн		Үдэш болохуй		Шөнө дундын		Шөнө дунд хэвийх		Уул завсарлах	
Цагийн	эх	адаг	эх	адаг	эх	адаг	эх	адаг	эх	адаг	эх	адаг
Ад	1	5	2	6	3	0	4	1	5	2	6	3
Сум	2	6	3	0	4	1	5	2	6	3	0	4
Ан	3	0	4	1	5	2	6	3	0	4	1	5
Бу	4	1	5	2	6	3	0	4	1	5	2	6
Ба	5	2	6	3	0	4	1	5	2	6	3	0
Суг	6	3	0	4	1	5	2	6	3	0	4	1
Са	0	4	1	5	2	6	3	0	4	1	5	2

Хагасын эзэн Бархасвадь ургахын үест Шимунасын цагийн завсар хийгээд Санчир ургахын цагт Төгс язгуурт ургах болой. Төгс язгуурт өөрийн цагтаа ургахын зурхай нь: тунцодын хагас нижгээдэд ээлжийн гараг нижгээд хийгээд хамтад лус нижгээд ургах болой. Адъяад Таалай (མཐའ་ཡས།), Сумъяад Норжай (ནོར་རྒྱས།), Ангарагт Жогбо (འཇོག་པོ།), Будад Довжүү (སྟོབས་རྒྱལ།), Бархасвадьд Бадма (པདྨ།), Сугард Бадмачэн (པདྨ་ཅན།), Санчирт Дүнжон (དུང་སྐྱོང་།) сэлт төгссөний дараа Раху [38], Төгс язгуурт хамтад ургана.

Найман түн	Анх дугаар	Хоёр-дугаар	Гурав-дугаар	Дөрөв-дүгээр	Тав-дугаар	Зурга-дугаар	Дол-дугаар	Найм-дугаар
Ад	1	2	3	4	5	6	0	8
Су	2	3	4	5	6	0	8	1
Ан	3	4	5	6	0	8	1	2
Бу	4	5	6	0	8	1	2	3
Ба	5	6	0	8	1	2	3	4
Суг	6	0	8	1	2	3	4	5
Са	о	8	1	2	3	4	5	6

Түнцодын хагасын хэмжээ нь алин бодох өдрийнхөө өдрийн хэмжээ, шөнийн хэмжээг наймаар хувааж алин гарсан ноогдвор лугаа тохируулж Ригдэн ургахын цагт аливаа үйл бүхэн доройтон, сүйдэх болно. Ялангуяа идээ, ундаа эдлэхүй хийгээд өвчтөн эм ууваас хор мэт болюу. Түүний тулд машид гүнзгийрүүлэн тэвч. Эмчийн од тэргүүтний ургахуй ёс нь:

Тэр өдрийн наран одноос эхлээд **эмч, эмийн халбага, эмийн аяга, өвчтөн** дөрвийг дараалан долоо, долоогоор таслан саран одонд хүртэл тоолон танин мэдэх болой. **Эмчид** бууваас өвчний үндэс их, эмчийг удаан шүтэж үйлд гэж зарлигласан. Халбагад буувал

дараалан эдгэюү. **Эмийн аяганд** одвоос эм рашаан болно.

Өвчтөнд одвоос эм нь хор болюу. Эмчийн анх нь Эсүрва [39] тэнгэр, эмийн анх нь буцалсан ус гэж алдаршжээ. Өвчтөний анх нь Сэтгэлийн хөвгүүн ба өвчний анх нь эс шингэсэн бөлгөө. Эсүрва бээр Сэтгэлийн хөвгүүнд ус буцалгаж өгөөд амирлуулвай. **Өвчтөн гадагш явж болохгүй өдөр нь:** Хар барс, хар морь, цагаан морь хийгээд хөх барс, хөхөгчин туулай, шарагчин туулай болой. "**Тэвчих хэрэгтэйг эс тэвчвээс өөрөө үхмүй**" хэмээн урдын арш [40] нар номлосон буй.

Өвчтөний эдгэх, үхэхийг шинжлэх нь:

Насны тоонд нэгийг нэмээд, бас өвдсөн өдрийн тоог нэм. гурваар үржүүлж, есд хуваасны үлдэгдэл гурав, зургаа, бинт гарах нь магадтай. Гурав гарвал өвчин хүнд ч амин насанд гэм үгүй. Бинт гарвал магадтай үхмүй. Зургаа гарвал засал үгүй өөрөө амирлана. Сард урган эдлэхүй [41] ба бидэнд хүчир **дөрвөн цаг нь: Битүүнд** Далайд хүчийг үүсгэн, лусын хаан Эс бүлээдсэн захиран үйлдээд лус нар хямран чуулахуй тул хүчир. **Шинийн**

найманд тэнгэрийн эрхэт Хурмаст шадар эрхшээгч гучин хоёр тэнгэрийг эргэнэ. Номын хуримыг зохиохуй тул хүчир. **Арван таванд** Сүмбэр уулын хөндийд шимунасын хаан Гааравванчүгт (དགའ་རབ་དབང་ཕྱུག།) шадар агч лагчаа сэлт тэнгэр лүгээ цэрэг хөдөлгөхүй тул хүчир. Хорин хоёрт Вишнү тэнгэр найман аймаг лугаа сэлт төрөлхтөнийг хээлэн зурахуй тул хүчир. Энэ үед өвдвөл хурал цуглаан хийх, хатуу үйлийг тэвч их муу.

Өдрийн тоо	1 11 21 6 16 26	2 12 22 7 17 27	3 13 23 8 18 28	4 14 24 9 19 29	5 15 25 10 20 30
Анх Цагийн Хүрдэний арвидах, буурах, махбода, хүсэлийн эрдэм, эгшиг гийгүүлэгч, доор нь эгшиг буухын хурын эгшиг гийгүүлэгч тэргүүтэн	нялх огторгуй дуу а да а да шороо үнэр	залуу хий хүрэлцэхүй и ти и на ус амт	идэр гал амт ри дри ү ба гал дүрс	хөгшин ус дүрс ү дү э па хий хүрэлцэхүй	нас төгссөн шороо үнэр ли ли о ва огторгуй дуу

Зөөлөн, хатуу үйл хийгээд ялангуяа дайсныг номхотгох, хатуу үйл, нялхын цагт тэнд өчүүхэн буянтай. Залууд өмнөхөөс өчүүхэн дээр (сайн). Идэрт дээд буянтай болой. Хөгшинд муу, түүнд ч унтрах буюу үхэхүй тул муу. Тэр үест үйлийг бүү үйлд. Ялангуяа эгшиг жаргахуйн үр нь муу. Тийм болохоор гийгүүлэгч жаргахуй зөөлөн. Занма ха ни андаа га тав ургах ёс, үрийн номлол сэлтийг бусдаас хар.

Шар зурхайн ёсноос гарсан цагийн сайн, муyг үзүүлсэн алтан орд хэмээн алдаршсан оршвай

12 цаг	хулгана	үхэр	бар	туулай	луу	могой
хулгана морь	алтан ордон	тэнгэр-ийн эм	цагаан бар	оюу эрдэнэ	тэнгэр-ийн там	хар мэлхий
үхэр хонь	тэнгэр-ийн цааз	улаан алаг	алтан ордон	тэнгэр-ийн эм	цагаан бар	оюу эрдэнэ
бар бич	хөх луу	гэгээн орд	тэнгэр-ийн цааз	улаан алаг	алтан ордон	тэнгэр-ийн эм
туулай тахиа	амь сахигч	хар од	хөх луу	гэгээн орд	тэнгэр-ийн цааз	улаан алаг
луу нохой	тэнгэр-ийн там	хар мэлхий	амь сахигч	хар од	хөх луу	гэгээн орд
могой гахай	цагаан барс	оюу эрдэнэ	тэнгэр-ийн там	хар мэлхий	амь сахигч	хар од

12 цаг	морь	хонь	бич	тахиа	нохой	гахай
хулгана морь	амь сахигч	хар од	хөх луу	гэгээн орд	тэнгэр-ийн цааз	улаан алаг
үхэр хонь	тэнгэр-ийн там	хар мэлхий	амь сахигч	хар од	хөх луу	гэгээн орд
Бар Бич	цагаан барс	оюу эрдэнэ	тэнгэр-ийн там	хар мэлхий	амь сахигч	хар од
Туулай Тахиа	алтан ордон	тэнгэр-ийн эм	цагаан бар	оюу эрдэнэ	тэнгэр-ийн там	хар мэлхий
Луу Нохой	тэнгэр-ийн цааз	улаан алаг	алтан ордон	тэнгэр-ийн эм	цагаан бар	оюу эрдэнэ
Могой Гахай	хөх луу	гэгээн орд	тэнгэр-ийн цааз	улаан алаг	алтан ордон	тэнгэр-ийн эм

Алтан ордон, тэнгэрийн эм, оюу эрдэнэ, амь сахигч хийгээд **хөх луу, гэгээн ордон** нь **сайн зургаан цаг** болой. Эдгээр нь жил, сар, өдрийн хар хийгээд гараг одны барилдлагын муу гэм тэргүүтэн бүхнийг дарахын дээд гэж алдаршсан тул тэр үест алин үйлдсэн бүхэн буян болно. Жил тэргүүтэн ямар мэт сайн боловч цагаан

барс тэргүүтэн муу цаг хийгээд барилдлага тэргүүтнээр буян бус, өлзий бус болох амой.

Хар өдрийг барих хүснэгт нь:

Туулай, тахиа өдрийн хулгана, морь цаг нь хар	луу, бич өдрийн үхэр, хонь цаг нь хар
Могой, гахай өдрийн бар, бич цаг нь хар.	морь, хулгана өдрийн туулай, тахиа цаг нь хар
үхэр, хонь өдрийн луу, нохой цаг нь хар	бич, бар өдрийн могой, гахай цаг нь хар

"Өлзий бус дөрвөн өдөр нь: Шинийн долоон, арван зургаанд гэм магадтай ирмүй "Нити" гэдэг номыг уншуул. Шинийн дөрвөнд өлзий бус. Арван есөн, хорин найманд ч муу. Үнэнийг үл барин, эвдрэхийн үүд гарна" хэмээн зарим үзлэгт буй.

Тансагийн ёсны жаран өдрийн үр:

Махбода Өдөр	мод	гал	шороо	төмөр	ус
Бар	0	0	0	X	0
Туулай	0	0	0		
Луу	X	X	X	X	0
Могой	X	X	X	X	X
Морь	0	X	X	0	X
Хонь	0	X	0	X	X
Махбода Өдөр	мод	Гал	шороо	төмөр	ус
бич	0	0	0	0	X
тахиа	0	0	0	0	X
нохой	0	0	0	0	X
гахай	0	X	O	O	X
хулгана	0	0	X	0	0
үхэр	0	0	0	0	0

Үүний 0 нь сайн, Х нь муу хэмээн мэдүүштэй.
Таван дагина [42]-ын хүрд

Дагины нэр	Дорж дагина	Радна Дагина	Бадма дагина	Гарма дагина	Буда дагина
Өдрийн тоо	1 6 11 16 21 26	2 7 12 17 22 27	3 8 13 18 23 28	4 9 14 19 24 29	5 10 15 20 25 30
Дорно одвол	хэрэгтэй хэрэг бүтнэ	юу хүссэн бүтнэ	олз олно	хоосон гарт урвана	дайсантай учирна
Өмнө одвол	үйл үл бүтнэ	хэрэг ноттой бүтнэ	дайсантай учирна	олз олно	хэрэгтэй хэрэг бүтнэ
Өрнө одвол	дайсантай учирна	Олз Олно	хэрэг ноттой бүтнэ	юу санасан бүтнэ	хоосон гарт урвана
Умар одвол	санасан хэ-рэг бүтнэ	Дайсантай учирна	үйл лүгээ үл учирна	доройтол зохисгүй	олз олно
Завсарт одвол	олз олно	үйл үл бүтнэ	санасан хэ-рэг бүтнэ	дайсантай учирна	ноттой хэрэг бүтнэ

Замын зурхайн зургаан аймаг буюу зургаан дэлбээн хүрдний замд орохуй өдөр "Нарны гэрэл" судраас:

1, 7, 13, 19, 25	Эрхтэн өдөр дорно зүгээс бусдад хүрвээс санасан хэрэг бүтнэ. Амраг лугаа учирна. Ялангуяа бар өдөр замд гарваас сайн.
2, 8, 14, 20, 26	Усны шүхэр хэмээнэ. Морь унаа үхнэ. Дайсан бүхнээ учирна. Эд алдана. Ялангуяа туулай өдөр замд гарвал муу.
3, 9, 15, 21, 27	Жимхан ([illegible]) гэдэг өмнөөс бусад зүгт одвоос худалдаанаа хожно. Санасан хэрэг бүтнэ. Ялангуяа луу өдөр замд гарвал сайн.
4, 10, 16 22, 28	Шүнян ([illegible]) гэдэг өрнөөс бусад зүгт одвоос их хүмүүн лүгээ учирна. Эд ар-вижна. Ялангуяа могой өдөр сайн.

5, 11, 17 23, 29	Шинян (ཞིང་ཡང་།) гэдэг өрнөөс бусад зүгт хүрвээс архи, мах лугаа учирна. Ялангуяа морин өдөр замд гарвaас сайн.
6, 12, 18 24, 30	Раху гэдэг зэрлэг хэрцгий хүмүүн лүгээ учирна. Өөрөө шархадна, эдээ алдана. Ялангуяа дорно ба хонь өдөр замд гарвaас сайн.

Үсгийн махбода

Огторгуй	Хий	Гал	Ус	Шороо
ཨ།	ཡ།	ར།	о	о
ཀ།	ཤ།	ར།	о	о
ཏ།	ཞ།	ར།	о	о
ཟ།	ཛ།	ར།	ཁ།	ས།
ཞ།	ཚ།	ར།	མ།	ལ།
ང།	ཙ།	ར།	བ།	ན།
ག།	ཇ།	ར།	ཕ།	ད།
ཁ།	ཆ།	ར།	པ།	ཐ།
ག།	ཨིཙ	ར།	ཨུ།	ཏ།

Гурван барилдлага тохиов хэмээн алдаршсан, утгандаа дөрөв тохиосныг энэ мэт өгүүлмүй. Баясгалан өдөр, Ангараг гараг, Гирдиг бядагч одон, (ཨ།) эгшиг урган тохиох үест бодгал А нэртэн байлдаанд орох, өвдөх, оронд одохуй буюу эмэгтэй нөхөр лүгээ уулзахаар одохуй, гол суурь тавих, худалдаа арилжаа тэргүүтэн алинд ч муу. Өвдвөөс үхэх буюу байлдаанаа шархдах, үйлийг үйлдвээс үр дүн нь муу боловсроно.

Сайн өдөр, Буд гараг, Мэг бядагч одон, И (ཨི།) эгшиг урган тохиохын үест бодагал И нэртэнд урд мэт муу. Ялгуусан өдөр, Бархасвадь гараг, Аслис гүйгч одон, Ү (ཨུ།) эгшиг тохиосон өдөр Ү нэртэн үйл алиныг эхэлсэн ч үр дүнгүй. Хоосон өдөр, Сугар гараг, Даниста бядагч

одон, Э (ཨེ) эгшигтэй тохиохын үест Э нэртэнд өмнө мэт муу. Төгс өдөр, Санчир гараг, Барани гүйгч одон, О (ཨོ) эгшиг лүгээ тохиохын үест О нэртэн дийлдюү. Бас бус Баясгалан өдөр тохиовоос А нэртэн байлдаанд орвол муу. Өвдвөл өнөд нэрмэгдюү. Сайны өдөр, Сумъяа гараг тохиовоос И нэртэнд өмнө мэт муу болох тул нягтад шинжил

	Бар, морь, нохой			Гахай, хонь, туулай	

	Тахиа, үхэр, могой			Хулгана, луу, бич	

Хийморь доройтох насны тоо нь		
5	21	37
9	25	41
13	29	45
17	33	.

Засал нь:

үүнээ бууваас эд, малд муу тул "Цагаан шүхэрт"-ийн хишиг даллага авахуул.

үүнээ бууваас нас, аминд муу тул насан бүтээл, үхлийг хуурах гүрэм тэргүүтэнд шамд.

үүнээ буухын цагт биед гэм болох тул бурхан, сахиусыг тахиж, хийморийн дарцаг хийсгэ.

үүнээ бууваас усан балин гарга, хийморийн сан талби, дөрвөн зүгт цагаан лавай үлээ.

"Хийморийг үүсгэх зан үйл" (རླུང་རྟ་བསྒྲུབ་པའི་བཀོད་པ) -ээс "Өөр, өөрийн хийморь махбода лугаа тохирсон бөсөнд хөвгүүн махбода лугаа тохирсон будгаар хийморийн тогтоолыг бичиж үйлд. Нөхөр махбода лугаа тохирсон бөсөөр зүүж цардаад хий. Дайсны өнгө лүгээ тохирсон хэл хийж, өөр, өөрийн тохирсон модонд зүүгээд газарт хатга" хэмээн зарлигласан тэр ямагтыг үлгэрлэн өгүүлбээс:

Бар, морь, нохой гурван жилтний хийморийн дарцаг нь шар бөс, бэхээр хийморийн тогтоолыг бичиж үйлд. Захаар нь ногоон өнгөөр цардан хүрээлж үйлд. Хэл нь улаан өнгөтэй. Модон бэрээ (иш) нь цагаан өнгөтэй байна. Бусадыг түүгээр ухааран мэдэх болой.

Хүснэгтэд байгуулбал доорхи мэт.

Арван хоёр жилийн нэр	Хий-морийн мах бода	Бөсний өнгө	Тогтоо-лын өнгө	Эмжээ-рийн цардас-ын өнгө	Дарца-гийн хэлний өнгө	Иш модны өнгө	Хийс-гэх өдөр	Хийс-гэх зүг
бар, морь, нохой	төмөр	шар	хөх	ногоон	улаан	цагаан	цагаан бич	өрнө
Могой, тахиа, үхэр	ус	цагаан	ногоон	улаан	шар	хөх	Хараг-чин гахай	умар
бич, хулгана, луу	мод	хөх	улаан	шар	цагаан	ногоон	хөх барс	дорно
гахай, туулай, хонь	гал	ногоон	шар	цагаан	хөх	улаан	улаан могой	өмнө

Хүүхдийн төөрөг

12 жил	Бар	Туулай	Луу	Могой	Морь	Хонь
Хөвгүүн-ийг оронд оруулах өдөр	5	7	27	17	21	11

12 жил	Бич	Тахиа	Нохой	Гахай	Хулгана	Үхэр
Хөвгүүн-ийг оронд оруулах өдөр	5	8	7	4	2	27

Нялхсыг бусдад тэжээлгэх ёс

Нялхсын жил	Бар, могой бич, гахай	Үхэр, хонь, луу, нохой	Морь, хулгана туулай, тахиа
Тэжээгч эхийн жил	үхэр	туулай, тахиа	луу, тахиа

Нялхын жил	Хулгана, үхэр	Бар, туулай, луу, могой, морь, хонь бич	Тахиа, нохой, гахай
Оронд оруулахад сайн өдөр	6 8	10	8
Оронд оруулахад муу өдөр	3 5	3 5	3 5



Хүүхдийн оройд 1, аманд 2, 3, 4; мөрөнд 5, 6; эгэмд 7, 8; гарт 9, 10; зүрхэнд 11, 12, 13, 14, 15; хүйсэнд 16; нууцад 17; өвдөгт 18,19; шилбэнд 20, 21, 22, 23, 24, 25, 26 дахь одод байрлана.

Хүүхдийг шинжлэхдээ тэр өдрийн нарыг тэвэрсэн одыг оройд зурж (бичиж, Орч) үйлдмүй. Амад гурав, мөрөнд хоёр, эгэмд хоёр хийгээд гарт хоёр, зүрхэнд тав, хүйсэнд нэг, нууцны оронд нэг, өвдөгт хоёр, шилбэнд найман одыг байгуулан шинжилмүй. Шилбэнд төрвөл насан охор болно. Өвдөгт төрвөл тэнүүчлэгч болно. Нууцад төрвөл хурьцлаар сүйтгэгдэнэ. Хүйсэнд төрвөл гуйлгачин болно. Зүрхэнд төрвөл эд лүгээ төгөлдөр болно. Гарт төрвөл хулгайч болно. Эгэмд төрвөл зовлонтон болно. Мөрөнд төрвөөс үүргэчин болно. Аманд төрвөл ном лугаа төгөлдөр болно. Оройн ганц одонд төрвөөс хаан болох нь эргэлзээгүй.

Насыг шинжлэхүйг бусад дандар(тантар)-уудад зарлигласан буй. Хутагтаны орны мэргэдийн таалал таалал мэт энэхүү ёсыг бичэе. Матарын ордны сар шинэдийн нэгнээс гурван хүртэл саран зүүн салхинаа анхыг үйлдээд, үүр цүүрээс арван хоёр цагийн барилдлага баруунаас зүүнээ арвидан бядмуй. Түүнд гурваны өдөрт наран баруун салхинаа анхыг үйлднэ. Түүнчлэн урвалт үгүй арвижин гүйх нь алины үест ч бат. Түүнээс тавны өдөрт гэдрэг буцан хэрэхүй тэргүүтэн болно. Сарын хагаст хатуу өвчин нэгэн сараар ойр шадарыг сүйтгэнэ. Сарын хагас гуравт (хоёр сар хагаст, орч) буцаж, зургаан сараас инагш үхюү. Ялангуяа хамрын хий үл юүлэхүй нэг ямагтад амьсгал хоногийн төдийд гүйж, сар, хоног төдийд сэргэх, үхэхийг доорхи хүснэгтэд тодорхой үзүүлсэн тодорхи мэт болой. Тэр мэтийн ёс нь хамрын хий гурван хоног бүрээс баруун, зүүнээ юүлээд, буцаж бядахын хооронд үхэхүй ёр үгүй . Буцан хоног мөч болсон төдий тоогоор жил, сар, хоног төдийд үхэх болюу. Өөрийн төрсөн сар, од, өдөр, гараг,

үйлдэгч, барилдлага, орд долоо хойно хэзээ тохиохын цагт үхлийн ёр гарваас, алин гарсан тоогоор магадтай үхнэ хэмээн гарсан хийгээд төрсөн од юугаан мэдэхгүй болохоор арван хоёрдугаарын арван зургаанаас харах болой.

Эсбөгөөс хамрын гурван мөрд оршихуйн нэгэн хоногт бядахыг нэгэн хоног хийгээд бас Хонь, Жинлүүрийн цагт тэгш гүйн үйлдэхийн үест нүд татваас нэгэн хоног хийгээд хамар хоёулаас арван хоног гүйвээс хэзээ юүлэхүй бээр үхнэ хэмээн номлосон буй. Үхлийн ёр гарсан ч амийг золих, насны бурхныг бясалган тахих, үүр цүүрээр хумхтан хийг барихуй тэргүүтэн гадна, дотнын үхлийг хуурахуй бээр насыг уртатган одуулж болох амой.

Мөч	Жил сар өдөр	14 0 0	12 0 0	11 10 12	10 0 0	9 10 12
хийн хэмжээ	өдрийн мөч	0 15	0 30	0 36	1 0	1 36
мөч	Жил сар өдөр	1 4 0	1 0 0	0 11 18	0 10 24	0 9 18
хийн хэмжээ	өдрийн мөч	14 0	15 0	16 0	17 0	18 0

Мөч	Жил сар өдөр	8 0 0	7 10 12	7 0 0	4 10 12	4 0 0
хийн хэмжээ	өдрийн мөч	2 0	2 36	3 0	3 36	4 0
мөч	Жил сар өдөр	0 8 0	0 6 0	0 5 0	0 5 0	0 4 0
хийн хэмжээ	өдрийн мөч	19 0	20 0	21 0	22 0	23 0

Мөч	Жил сар өдөр	3 7 6	3 0 0	2 11 6	2 9 18	2 7 6
хийн хэмжээ	өдрийн мөч	4 36	5 0	6 0	7 0	8 0
мөч	Жил сар өдөр	0 4 0	0 3 0	0 2 0	0 1 0	0 0 16
хийн хэмжээ	өдрийн мөч	24 0	25 0	26 0	27 0	28 0

Мөч	Жил сар өдөр	2 4 0	2 0 0	1 11 12	1 9 18	1 7 6
хийн хэмжээ	өдрийн мөч	9 0	10 0	11 0	12 0	13 0
мөч	Жил сар өдөр	0 0 10	0 0 5	0 0 3	0 0 2	0 0 1
хийн хэмжээ	өдрийн мөч	29 0	30 0	31 0	32 0	33 0

Тэр одны мөчийн тоо жарыг дөрвөн хөлд хуваасны хувь бүр нь насны хэмжээ болно.	Саран одны дөрвөн хөлийн мөчний хувь алинд төрсний насны тоо	Үхлийг хуурахуй зан үйлээр насанд нэмэгдэх шалтгаант жилийн тоо
Нэгдүгээр хөлийн мөч 15	мөч 1-15 бол насны дээд 99	Анхдугаар хувьд нэмэгдэх жил үгүй
Хоёрдугаар хөлийн мөч 30	мөч 16-30 бол насны дундач 75	Хоёрдугаар хувьд нэмэгдэх шалтгаант жил нь 3
Гуравдугаар хөлийн мөч 45	мөч 31-45 бол насны дунд 55	Гуравдугаар хувьд нэмэгдэх шалтгаант жил нь 6
Дөрөвдүгээр хөлийн мөч 60	мөч 46-60 бол насны доод 35	Дөрөвдүгээр хувьд нэмэгдэх шалтгаант жил нь 9

Насны хэмжээг тооцохуй ёсны товч хураангуй нь: Урьд өдрийн эдэлбэрийг жараас хасч, үлдэгдэлд одоогийн өдрийн эдэлбэрийг нэмбэл, түүнийг насны огоот төгс эдэлбэр гэдэг. Наран одноо өмнө, хойно

дараалан алин бодох өдрийн сар шинийн эдэлбэрийг нэмбэл тус, тусын өдрийг тэвэрсэн саран од ургана. Урьдыг хойтохоос хасвал сарны огоот төгссөн эдэлбэр гарна. Сарны огоот төгссөн эдэлбэрийг чинлүүрт шилжүүлж, насны огоот төгссөн эдэлбэрийн чинлүүрт шилжүүлснээр хуваасан ногдвор мөч, үлдэгдлийг жараар үржүүлж, чинлүүрийг нэмээд өмнө мэт хуваасан ногдвор нь чинлүүр, бас үлдэгдлийг зургаагаар үржиж, амьсгалыг нэмээд хувааж олвол ногдвор нь амьсгал мөн болой. Үүнийг нэг мөчний нутгийн эдэлбэр гэнэ. Тэр ямагтыг жард хуваасан ногдвор нь нэг чинлүүрийн нутгийн эдэлбэр хэмээгдмүй. Тэр чинлүүрийг зургаад хуваасан ногдвор нь нэг амьсгалын нутгийн эдэлбэр хэмээх болно. Алин бодож буйн өдрийн эдэлбэр эхэлснээс эх аван төрсөн цагийн завсар дахь мөч тэргүүтэн ямар мэт өнгөрсөн хэмжээг саваны сүүдэр буюу цагийн хэмжээний хүрд тэргүүтэнд шүтэж олсон өдрийн өнгөрсөн эдэлбэрийн мөч, чинлүүр, амьсгал гурваар нутгийн гурван эдэлбэрийг дараалан үржүүлж, өөр, өөрийн хүрдээр хуйлсан гурвын мөч тэргүүтэн гурвыг тус, тусд нь нэгнээ боон товчлохын цагт сарны нөгчсөн эдэлбэр бүтнэ хэмээн номлосон болой. Урьд өдрийн өдрийг тэвэрсэн саран одонд сарны нөгчсөн эдэлбэрийг нэмбэл увьдаст саран од бүтэв хэмээхүй. Алин бодохуй цагийн саран одны тэр мөчийг арван тавд хуваасан ногдворт нэгийг нэмсэн тэр нь дөрвөн хувийн насны хэмжээ алин мөнийг үзүүлэх болой. Үлдэгдлийг гурван оронд тавьж, дээрээс нь 1, 0, 24-өөр үржүүлж, доороос нь 30, 12, 15-аар хуйлбал дараалан жил, сар, өдөр ургана. Хувь алины насны хэмжээнээс хасвал хамт төрөхүй насны хэмжээ ургана. Түүнээ насыг хуурахуй

жилийн тоог нэмбээс огоот төгс насны хэмжээ гарна. Насны ахуй үес түүнийг дараалан есөн гараг бээр ямар мэт эрхшээх ёс нь огоот төгс насны хэмжээ түүнийг есөн гараг тус, тусын жилийн тоогоор үржүүлж, ерэн тавд хуваасан ногдвор нь жил, үлдэгдлийг арван хоёроор үржүүлж олвол саран, гучаар үржүүлж олбол хоног, жараар үржүүлж олвол мөч болой. Тэр мэт тус, тусын хэмжээг хялбар дөхөм бүтээнэ. Тус, тусын үрийн дэлгэр номлол тэргүүтнийг гол судруудаас хараарай. Умар явдалд хүчин төгс цагаан зүгийн амирлангуй, дэлгэрэнгүй үйл бүхнээ өлзийтэй. Өмнө явдалд ялангуяа шинэдэд наран лүнд оршихуй (ཉིངས་ཞུགས།) үест эрхшээх, хатуу үйлүүд хүчин төгс болно. Адъяа, Ангараг, Санчир, Раху, Гэдү нь хилинцэт хатуу, Сумъяа, Буд, Бархасвадь, Сугар дөрөв нь буянтай амирлангуй зөөлөн гараг гэж огоот алдаршсан.

Гарагийн **дэлгэрэх, доройтох, хямрах, буурахын үр** нь: **Дэлгэрэхэд** өвчний уг үгүй. **Буурахад** ховоор амьдрах, **хямрахуйд** золигийг зан үйл ихэд хэрэгтэй. **Доройтохуйд** үхэл тасран, өвчний уг их. Амьд, үхэгсэдийн үйл алиныг ч тэвч. Умар явдалд нарны хүчин арвидах болохоор тэр үест хатуу гараг хүч ихтэй ба өмнө явдалд сарны хүчин арвидах тул зөөлөн гарагууд хүчин төгс болой. Раху-ийн хоншоор, сүүл нь үргэлжид хүчин ихтэй болой. Буд, Бархасвадь түргэн явдалд Санчир, Сугар алгуур явдалд, Ангараг, Гэдү хажуу явдалд хүч ихтэй, бусдад тэгш үйлдэхүй болой. Адъяа, Бархасвадь, Сугар гурав нь өдөр хүч ихтэй, Сумъяа, Раху, Санчир шөнө, Буд хоёуланд нь хүчин төгс. Бархасвадь, Сугар цагаан зүгт бөгөөд Адъяа, Санчир хар зүгт, хоёуланд нь Ангараг, Буд, Сумъяа хүч

ихтэй бөлгөө. Сумъяа, Сугар Үхэр тэргүүтэн эм ордонд хүч ихтэй, бусад гараг нь эр ордонд хүч ихтэй болой. Бас бус гарагуудын тэврэлт, нүүрс, утаа тэргүүтнийг энд өгүүлвээс аль гараг, аль гүйгч одны дээр оршихуй нь өөр, өөрийн тэврэлт бөгөөд идэж гүйцсэн нь нүүрс, идэхүй шалтгаант нь соёо, нигуурын хорлол нь алин гараг Ашуванид оршихуйд баруун соёо Цэста, зүүн нь Ровагини, Бурбабэлгүнийд нигуур тогтсон болой.

Бусдыг хүрдэнд тодорхой харах хэрэгтэй. Раху баруунаа эргэн одохуй тул Хоншоор, Сүүлд нүүрсийг буруугаар эргүүлэн тоолно. Хатуу гарагийг баруун зүгт, зөөлөн гарагийг зүүнд тоолох бөлгөө. Адъяа өөрийн явдлаар арван хоёр, түүнчлэн Ангараг гурав, Санчир найм, зөөлөн гараг Раху зүүнээ эргэх бөлгөө.

Гирдигийн хөл лүгээ Сумъяан орон, умар зүгт үсэг харахуй ба түүнчлэн Буд долоо ба Бархасвадь зургаа, Сугар тав, Раху есд тоолох мөн. Тэр ч Раху-гаас бусад гараг түргэн, алгуур, гарахуй явдлаар эрхшээсэн гэж номлосон бөлгөө. Хажуу явдлаар явахын үест хатуу гарагийг баруун, зүүнийг эргүүлэн тоолно.

Нүүрс	Тэврэлт	Утаа	Нигуур
Үхэлд тулмуй	Өвчин тусмуй	Хэрэг үл бүтнэ	Аюул тусна

Зөөлөн гарагийн нүүрс, утаа, тэврэлт хорлол үгүй болой.

Гараг	Ад	Су	Ан	Бу	Ба	Суг	Са	Раху
Хар-ахуй газ-рын үр	Эд барагд-на	Аюул ихэд гарна	Үхэх буюу хэл ам болно	Дай-сан гарна	Амраг садан сүйд-мүй	Хэрэг үл бүт-мүй	Үхэх буюу хэл ам болно	Хатуу хэл ам гарна үхэл

Соёо	1	2	3	Соёо	1	2	3
Хатуу гарагийн үр	Хэрэг буурна	Өвчин гарна	Үхнэ	Зөөлөн гарагийн үр	Идээ ундаа лугаа хагац-на	Идээ ундаа лугаа хагацна	Хижиг болно, эд барагдна

Зургаан соёо	Төрсөн газар	Үйлийн газар	Үйлдэх газар	Тэм-дэгт газар	Ананда	Винаша-га	Сэтгэлт газар
Зур-гаан хорлол баригч-ийн үр-ийн номлол-ын ху-раангуй	Өвчин болно, эд ба-рагдна. Хэл ам болно. Дайсан лугаа тэм-цэлд-нэ	Нөхөр харшлан тэмцнэ. Урлалын үйл үнэ үгүй үйл үл бүтнэ	Нөхөр, Садан, амраг, садан лугаа хуран хага-цна	Санасан үйл үл бүтнэ	Хатуу хямрал, өвчин хижиг болно	Буян буур-муй	Сэтгэлд их зовлон болно

Нигуур хатгахад саран од ургавал зөөлөн гараг жад, хатуу гараг их жад барилдлага бөгөөд хорлол ихтэй. Тэр тэргүүтэн дэлгэрэнгүйг гол судраас хараарай.

Газрын эздийн үр

Газрын эзний гүйхүй ёсыг өгүүлэе. Жил, сар, өдөр, цагийн газрын эзний оршин, гүйхүй тэргүүтэн миний (Зохиогчийн) доор байгуулсан мэт мөн болой. Үүнд өдөрт гүйгчдийг хүснэгт (Ухахад хялбарыг бодож, өдөр

бүрээр дараалуулан бичив, Орч)-д байгуулж, дэлгэр өгүүлсэн нь:

